

УЛСЫН ТӨСВӨӨС 2010 ОНД САНХҮҮЖҮҮЛСЭН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН



**ГҮЙЦЭТГЭЭГҮЙ АЖИЛД САНХҮҮЖИЛТ ОЛГОДОГ ЯВДАЛ
АРИЛАХГҮЙ БАЙНА**

<p><u>Тайланг бэлтгэсэн:</u></p> <p>ҮАГ-ын Гүйцэтгэлийн аудитын газар</p> <p><i>Захирал</i> Д.Ганбилэг</p> <p><i>Аудитын менежер</i> Х.Баярмаа</p> <p><i>Ахлах аудитор</i> С.Сэрчхорол Г.Цэдэнбалжир Ц.Гэрэл</p> <p><i>Ахлах шинжээч</i> У.Баярмаа Л.Эрдэнэчулуун</p> <p><i>Аудитор</i> З.Ариунзаяа Д.Болормаа П.Цэнгүүн</p> <p><i>Шинжээч</i> Б.Болормаа Д.Баттулга Ц.Цолмон Ш.Энхтайван Б.Саруул Ц.Эрдэнэчулуун</p> <p>2011 оны 4 дүгээр сар</p> <p>Уг тайланг ҮАГ-ын вэб сайт-аас үзнэ үү:</p> <p>Вэб сайт: www.mnao.mn</p> <p><i>Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 261885, 263755 дугаарын утас, 323266 дугаарын факсаар харилцана уу.</i></p> <p>ХАЯГ: <i>Үндэсний аудитын газар Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3, Засгийн газрын IV байр</i> <i>Улаанбаатар хот 15160 Монгол улс</i></p>	<p>Товчилсон үгсийн жагсаалт 3</p> <p>Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй 5</p> <p>Бүлэг 1 Төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний үр нөлөөг тооцохгүй байна 7</p> <ul style="list-style-type: none"> • Ерөнхий мэдээлэл • Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээнд олон жил дамжсан арга хэмжээ цөөнгүй байна 8 • Хөрөнгө оруулалтын төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжээгүй байна 9 <p>Бүлэг 2 Төрийн зарим төв байгууллага, гадаад харилцаа, хууль хүчний байгууллагын хөрөнгө оруулалтын хэрэгжилт 13</p> <ul style="list-style-type: none"> • Зарим төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг тооцохдоо ТЭЗҮ болон зураг төслийг үндэслээгүй байна • Зориулалтыг нь өөрчилсөн, зураг төсөвгүй, хэрэгжих боломжгүй төсөл, арга хэмжээ цөөнгүй байна 14 • ХАА-ны аргыг журмын дагуу сонгоогүй байна 14 • Чанар муутай техник хэрэгсэл худалдан авч, хөрөнгө оруулалтын бус шинж чанартай арга хэмжээг санхүүжүүлж байна 17 <p>Бүлэг 3 Дэд бүтцийн салбарын хөрөнгө оруулалтын хэрэгжилт</p> <ul style="list-style-type: none"> • Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг нэмж баталсан ч хэрэгжилт хангалтгүй байна 18 • Төлөвлөсөн төсөл, арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байна 20 • Гадаадын зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн дотоодын эх үүсвэрийн ашиглалт хангалтгүй байна 21 • Төсвийн хөрөнгөөр баригдаж буй автозамын ажлын гэрээний нөхцөл тодорхой бус, түүнд тавих хяналт хангалтгүй байна 21 • Хөрөнгийг ашиглагчид хүлээлгэн өгөөгүй, авлага, өглөгийн үлдэгдлийг баталгаажуулаагүй байна 23 <p>Бүлэг 4 Нийгмийн салбарт улсын төсвөөс санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын хэрэгжилт 24</p> <ul style="list-style-type: none"> • Зураг төсөв нь бэлэн болоогүй объект төлөвлөгдөж байна 24
--	--

- Өмнөх онуудын төлөвлөлтийн алдаа хөрөнгө оруулалтын цаашдын хэрэгжилтэд сөргөөр нөлөөлсөөр байна 25

Бүлэг 5 Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн салбарын хөрөнгө оруулалтын хэрэгжилт

- Төсвийн тодотголоор нэмэгдсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ салбарын бодлоготой уялдахгүй байна 29
- ХАА-г зохих хууль тогтоомжийн дагуу зохион байгуулаагүй байна 30
- Хөрөнгө оруулалтын гэрээнд зарим гол нөхцөлийг тодорхой заахгүй байна 31
- Өмнөх оны хөрөнгө оруулалтын гүйцэтгэл хангалтгүй байна 31
- Хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг үнэн зөв гаргаагүй байна 32
- **Дүгнэлт** 33
- **Холбогдох байгууллагын санал** 34
- **Зөвлөмж** 41

АТГ	Авилгатай тэмцэх газар
АЗГ	Авто замын газар
АХБ	Азийн хөгжлийн банк
БОАЖС	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
БОХХААХҮС	Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбар
БЗА	Барилга захиалагчийн алба
БУА	Барилга угсралтын ажил
БОСНААБГ	Барилга, орон сууц, нийтийн аж ахуйн бодлогын газар
БХС	Батлан хамгаалахын сайд
БГД	Баянгол дүүрэг
БЗД	Баянзүрх дүүрэг
БСШУС	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд
БНАЛАУ	Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БОЭТ	Бүсийн оношлогоо эмчилгээний төв
ГХС	Гадаад харилцааны сайд
ДШС	Дулааны шугам сүлжээ
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэр
ЖДҮХС	Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан
ЗТБХБС	Зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайд
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ИНЕГ	Иргэний нисэхийн ерөнхий газар
МУ	Монгол Улс
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
МЦХ	Монголын цахилгаан холбоо
МШХХТГ	Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газар
НХХС	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд
ОУБ	Олон улсын байгууллага
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
ӨМӨЗО	Өвөр монголын өөртөө засах орон
СХОГ	Санхүү, хөрөнгө оруулалтын газар
СХЗГ	Стандарт хэмжил зүйн газар
ТЭДС	Тариалан эрхлэлтийг дэмжих сан
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ТАЗ	Төрийн албаны зөвлөл
ТБОӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТББ	Төрийн бус байгууллага
ТНБД	Төрийн нарийн бичгийн дарга
ТНЖБАТХ	Төрийн нууцын жагсаалт батлах тухай хууль
ТБУСТХ	Төсвийн байгууллага, удирдлага санхүүжилтийн тухай хууль
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТШС	Тэргүүн шадар сайд
УБТЗ	Улаанбаатар төмөр зам
УГЕГ	Улсын гаалийн ерөнхий газар

УИХ	Улсын Их Хурал
УДШЕШ	Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч
УЕПГ	Улсын ерөнхий прокурорын газар
ҮХЦ	Үндсэн хуулийн цэц
ҮТЕГ	Үндэсний татварын ерөнхий газар
ХУД	Хан-Уул дүүрэг
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман улс
ХХҮХ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХХААХҮС	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд
ХЗДХС	Хууль зүй, дотоод хэргийн сайд
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХШҮГ	Хяналт, шинжилгээ үнэлгээний газар
ЦУОШГ	Цаг уур, орчны шинжилгээний газар
ЦДАШ	Цахилгаан дамжуулах агаарын шугам
ШС	Шадар сайд
ЭБЭХС	Эрдэс баялаг, эрчим хүчний сайд
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ЭХБУ	Эрчим хүчний барилга угсралт
ЭХГ	Эрчим хүчний газар
ЭНЭШТ	Эх нялхсын эрдэм шинжилгээний төв

АУДИТЫН ЗОРИЛТ, АРГА ЗҮЙ, ХАМАРСАН ХҮРЭЭ

1. Аудит хийсэн үндэслэл

Аудитыг УИХ-ын НББСШУ-ны Байнгын хорооны санал, МУ-ын Ерөнхий аудиторт ҮАГ-аас 2011 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийв.

2. Аудитын зорилт

Улсын төсвийн хөрөнгөөр 2010 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг шалгаж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв.

Аудитын зорилтыг хангахын тулд дараахь чиглэлээр аудит хийлээ. Үүнд:

- 2010 оны хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг үндэслэлтэй төлөвлөсөн эсэх;
- Худалдан авалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан эсэх
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, гүйцэтгэлийг үнэн зөв гаргасан эсэх

3. Хамарсан хүрээ

Аудитад төсвийн ерөнхийлөн захирагчид, тэдний эрхлэх асуудлын хүрээний зарим байгууллагуудыг хамруулав. ТНЖБТХ, ТБОНӨХБАҮХАТХ-ийн 3.3-т заасны дагуу БХЯ, ЦЕГ, ХХЕГ, ШШБЕГ-ын тусгай хэрэгсэл, тоног төхөөрөмж, ажил үйлчилгээг худалдан авах ажиллагааг шууд гэрээгээр гүйцэтгэсэн учир аудитад хамруулаагүй болно.

4. Арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, гүйцэтгэлийн аудитын гарын авлага, Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу дараахь арга зүйг ашиглав. Үүнд:

- Монгол Улсын 2010 оны төсвийн тухай хууль, төсвийн тодотголоор батлагдсан хөрөнгө оруулалтын судалгаа, материалыг гаргуулан авч харьцуулах;
- Улсын төсвийн хөрөнгөөр 2010 онд хийсэн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, гүйцэтгэлд дүн шинжилгээ хийх;
- ТБОНӨХБАҮХАТХ-ийн хэрэгжилтийг ТЕЗ-дын багцын хүрээнд түүвэрлэн шалгах;
- Орон нутагт хийгдсэн хөрөнгө оруулалтын хэрэгжилтийн талаар аймгийн аудитын газруудтай хамтран түүвэрлэн судалж үзэх;

- Сангийн яам болон холбогдох бусад байгууллагын ажилтнуудтай ярилцлага хийж, тодруулга авах;

Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын багуудын бэлтгэсэн дараахь салбаруудын тайланг нэгтгэн дүгнэх байдлаар энэхүү тайланг бичлээ. Үүнд:

- Төрийн зарим байгууллага, Гадаад харилцаа, хууль хүчний байгууллагуудад 2010 онд хийсэн хөрөнгө оруулалтын хэрэгжилт;
- Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын салбарын хөрөнгө оруулалтын хэрэгжилт;
- Нийгмийн салбарт улсын төсвөөс санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын хэрэгжилт;
- Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн салбарын хөрөнгө оруулалтын хэрэгжилт.

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ, судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Бүлэг 1: Төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний үр нөлөөг тооцохгүй байна

Ерөнхий мэдээлэл

1.1 Улсын төсвийн хөрөнгөөр 2010 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг ТБУСТХ болон СЯ-ны төлөвлөлт, дунд хугацаанд баримталж буй улсын төсвийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр болон ТЕЗ-дын ирүүлсэн саналд суурилан төлөвлөжээ.

1.2 Монгол Улсын 2010 оны төсвийн тухай хуулиар 2010 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд нийт 447.7 тэрбум төгрөг баталсан байна.

1.3 Монгол Улсын 2010 оны төсвийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар нийт хөрөнгө оруулалтын хэмжээ 530.9 тэрбум төгрөг болж өсчээ. (Хавсралт № 1)

Улсын төсвөөс санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийг төсвийн ерөнхийлөн захирагчдаар ангилж харуулбал¹
(сая төгрөгөөр)


№	Салбар	Төсөвт өртөг	Улсын төсөв	Нийт дүнд эзлэх хувь
1	ЗТБХБС	949960.2	193031.5	36.4
2	БСШУС	143377.0	75478.2	14.2
3	ЭБЭХС	178524.7	52218.1	9.8
4	ЭМС	103348.8	43346.9	8.2
5	НХХС	40120.5	38297.0	7.2
6	ХХААХҮС	232631.1	36085.7	6.8
7	СС	48894.9	20910.9	3.9
8	ХЗДХС	49714.7	16367.2	3.1
9	ЕС	26549.6	14749.6	2.8
10	ТШС	11553.3	11553.3	2.2
11	ШС	17618.2	8079.9	1.5
12	ЗГХЭГ-ын дарга	7253.6	6152.5	1.2
13	ГХС	6426.2	4071.4	0.8
14	БОАЖС	4620.9	3385.9	0.6
15	БХС	3283.8	3283.8	0.6
16	ШЕЗ-ийн дарга	1342.9	1342.9	0.25
17	УИХ-ын дарга	840.0	840.0	0.16
18	МҮОНРТ	500.0	500.0	0.09
19	УПЕГ	306.5	306.5	0.05
20	УЕА	200.0	200.0	0.04
21	ЕТГ	189.2	189.2	0.03
22	ҮХЦ-ийн дарга	163.5	163.5	0.03
23	УДШЕШ	118.8	118.8	0.02
24	ҮАБЗ	106.3	105.3	0.01
25	АТГ-ын дарга	91.4	91.4	0.01
26	ҮСХ-ны дарга	91.4	91.4	0.01
Нийт дүн		1827826.4	530960.9	100

1.4 Дээрх судалгаанаас харахад нийт хөрөнгө оруулалтын 46.2 хувийг дэд бүтцийн салбарт, 29.6 хувийг нийгмийн салбарт, 6.8 хувийг хүнс, хөдөө аж ахуй

¹ Монгол Улсын 2010 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн хавсралт

хөнгөн үйлдвэрийн салбарт, үлдсэн 17.4 хувийг бусад салбарт зарцуулахаар төлөвлөжээ.

1.5 2010 оны хөрөнгө оруулалтын хэмжээг 2009 оныхтой харьцуулахад төлөвлөгөө 109.7 тэрбум төгрөг буюу 26 хувиар, гүйцэтгэл 98.6 тэрбум төгрөг буюу 26.3 хувиар тус тус өсчээ.



Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээнд олон жил дамжсан арга хэмжээ цөөнгүй байна

1.6 Улсын төсвийн хөрөнгөөр 2010 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд өмнөх оноос шилжиж ирсэн болон дуусаагүй төсөл, арга хэмжээний тоо 0.7- 22.3 хувийг эзэлж байна.

1.7 2010 онд батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжих хугацаанд дүн шинжилгээ хийж үзэхэд олон жилээр үргэлжилж байгаа төсөл, арга хэмжээ нилээд байна.

1.8 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ ийнхүү сунжирч олон жил дамжин хэрэгжих нь хөрөнгө оруулалтын өртөг зардал өсөх, үр өгөөж буурах үр дагавартай юм.

2001 оноос эхлэн санхүүжигдсэн төсөл, арга хэмжээний тоо, төлөвлөгөө, гүйцэтгэл

(төгрөгөөр)

Төсөл, арга хэмжээний			Төсөвт өртөг		2010 оны төлөвлөгөө	
Хэрэгжих хугацаа	тоо	хувь	дүн	хувь	Дүн	хувь
2001-2010	1	0,1	7 319 300,0	0,4	524 000,0	0,1
2004-2010	1	0,1	7 754 200,0	0,4	1 033 100,0	0,2
2005-2010	3	0,3	3 698 100,0	0,2	680 400,0	0,1
2006-2010	6	0,6	14 422 400,0	0,8	3 999 500,0	0,8
2007-2009	4	0,4	16 330 000,0	0,9	4 751 700,0	0,9
2007-2010	50	5,0	148 402 100,0	8,1	55 065 300,0	10,4
2007-2011	3	0,3	12 766 400,0	0,7	1 820 300,0	0,3
2008-2009	4	0,4	19 087 500,0	1,0	3 160 600,0	0,6
2008-2010	77	7,8	140 003 200,0	7,6	64 924 700,0	12,2
2008-2011	24	2,4	117 313 700,0	6,4	42 053 900,0	7,9
2008-2012	2	0,2	29 430 200,0	1,6	2 000 000,0	0,4
2009-2010	32	3,2	49 585 000,0	2,7	21 929 100,0	4,1
2009-2011	11	1,1	35 287 800,0	1,9	10 800 000,0	2,0
2009-2012	2	0,2	7 000 000,0	0,4	1 900 000,0	0,4
2009-2013	1	0,1	2 060 400,0	0,1	1 857 200,0	0,3
2010	633	63,7	227 120 400,0	12,4	227 120 400,0	42,8
2010-2011	104	10,5	260 127 200,0	14,2	45 354 200,0	8,5
2010-2012	28	2,8	373 205 600,0	20,4	39 528 200,0	7,4
2010-2013	7	0,7	360 233 000,0	19,7	2 458 300,0	0,5
Дүн	993	100,0	1 831 146 500,0	100,0	530 960 900,0	100,0

1.9 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээ 2009 оныг эс тооцвол тогтмол өсөн нэмэгдэж байгаа боловч төсвийн нийт зардал ба цэвэр зээлийн дүнд эзлэх хувь хэмжээ 2007 оноос хойш байнга буурсан байна.

Төсвийн нийт зардалд эзлэх улсын төсвийн хөрөнгө оруулалт
(тэрбум төгрөг, хувиар)

Д.д	Үзүүлэлт	2005 он	2006 он	2007 он	2008 он	2009 он	2010 он гүйцэтгэл	2011 он Төл
1	Төсвийн нийт зардал ба цэвэр зээлийн дүн	764.6	1,237.0	1,747.3	2,466.8	2,336.6	3,107.9	4,084.1
2	Улсын төсвийн ХО	59.3	133.3	366.3	460.0	374.8	473.2	627.7
3	Төсвийн нийт зардалд эзлэх ХО-ын хувь	7.8	10.8	21.0	18.6	16.0	15.2	15.4

1.10 2010 оны төсвийн хөрөнгө оруулалтын барилга байгууламж, төсөл, арга хэмжээний нийт 473.2 тэрбум төгрөгийн гүйцэтгэлийг 2009 оны гүйцэтгэлтэй харьцуулахад 98.4 тэрбум төгрөг буюу 26.3 хувиар өсчээ.

1.11 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 2010 оны гүйцэтгэл батлагдсан төлөвлөгөөтэй харьцуулахад 89.1 хувьтай байна.²

1.12 Нийт хөрөнгө оруулалтын 85.9 хувь буюу 406.3 тэрбум төгрөгийг барилга байгууламж барихад, 5.9 хувь буюу 28.2 тэрбум төгрөгийг их засварын зардалд, 8.2 хувь буюу 38.7 тэрбум төгрөгийг тоног төхөөрөмж, техник хэрэгсэл худалдан авахад зарцуулжээ.

Хөрөнгө оруулалтын төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжээгүй байна

1.13 2010 оны төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээ өнгөрсөн оноос өссөн боловч зарим томоохон арга хэмжээ хэрэгжээгүй нь төлөвлөсөн санхүүжилтийг бүрэн ашиглаагүй, гүйцэтгэл дутуу, зээлийн хөрөнгө болон дотоод нөөцийг хангалтгүй ашигласантай холбоотой байна.

1.14 2010 онд ашиглалтад оруулах барилга байгууламжийн зарим арга хэмжээ төлөвлөсөн хэмжээнд хүрч хэрэгжээгүй бол зарим арга хэмжээ давж биелсэн байна. Үүнийг судалгаагаар харуулбал,

№	Барилга, байгууламжийн төрөл	Хүн	2009 оны гүйцэтгэл	2010 он	
				төлөвлөгөө	гүйцэтгэл
1	Хатуу хучилттай зам	км	220.2	401.6	227.7
2	Хайрган зам	км	40	10.3	-
3	Төмөр бетон гүүр	у/м	498.3	1379.8	602.3
4	Эрчим хүчний шугамд холбогдсон сум	тоо	43	6	1
5	Сэргээгдэх эрчим хүчээр хангагдсан сум	тоо	2	1	-
6	Ашиглалтад орсон ЦДШ	км	665	402	68.8
7	Ашиглалтад орсон ЕБС	суудал/тоо/ш	5780/17	4128 /14	4668/13
8	Ашиглалтад орсон хүн эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагын барилга	ор/тоо/л	150/12	355/17	325/18
9	Ашиглалтад орсон цэцэрлэг	ор/ тоо/ш	1530/18	1820/20	2640/29
10	Ашиглалтад орсон соёлын төв	суудал/тоо/ш	3800/16	745/7	2890/13

² Эх сурвалж: Сангийн яам, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтэс

11	Сургуулийн спорт заал	м ² /тоо	3600/12	1150/4	2016/7
12	Дотуур байр	ор/тоо	1549/14	580/5	1045/9
13	Инженерийн хийцтэй худаг	тоо	252	258	258
14	Услалтын систем байгуулах	га/тоо	3733/68	3000/55	3155/50
15	Услалтын системийн засвар	Гал/тоо	1588.5	700/9	780/4
16	Дулааны шугам	км	40.45	1.6	14.4
17	Бохир усны шугам	км	42.6	6.9	6.8
18	Цэвэр усны шугам	км	34.23	33	29.8
19	Өргөлтийн насос	ш		5	2
20	Цэвэрлэх байгууламж	ш		2	2
21	Усан сан	ш		4	1
22	Үерийн далан	км		9	4.5

Эх сурвалж: Сангийн яам, Төсвийн хөрөнгөө оруулалтын хэлтэс

1.15 УИХ-аас баталсан 2010 оны хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнээс бүтээн байгуулалтын томоохон арга хэмжээнүүд (хатуу хучилттай зам 43.3 хувь, ЦДШ 82.9 хувь, төмөр бетон гүүр 43.6 хувиар тасарсан) бүрэн хэрэгжээгүй байхад хүүхдийн цэцэрлэг, дотуур байр, соёлын төв зэрэг төлөвлөгдөөгүй барилга байгууламжийг 1.45-1.9 дахин давуулж гүйцэтгэсэн байна.

1.16 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх үндэслэл болон гүйцэтгэгчийн боломжит нөөц, ур чадвар, үр дүнг бодитой тооцож үнэлэхгүй байна.Тухайлбал,

(сая төгрөгөөр)

№	Үзүүлэлт	Хэрэгжүүлэгч байгууллага	Төсөл, арга хэмжээний агуулга	2010 оны	
				Төлөвлөгөө	Санхүүжсэн дүн
1	2010 оны төлөвлөгөөний дагуу ашиглалтад орох ёстой боловч ороогүй, төсөл, арга хэмжээ, барилга байгууламж	ЭБЭХЯ	Дизель станц худалдан авч суурилуулах, дэд станцын барилга, зураг төсөө, цахилгаан хангамжийн тоног төхөөрөмж, ЦДАШ-ын шинэчлэл,	23 753.4	8 514.8
		ЗТБХБЯ	Авто зам Үүнээс: Гадаадын зээлээр хэрэгжих төслийн дотоод эх үүсвэр	9 094.3	595.5
			Дотоодын хөрөнгөөр баригдах авто зам	16 938.8	7 360.4
			Гүүр	568.8	403.8
2	2010 оны төлөвлөгөөний дагуу санхүүжилт аваагүйгээс хэрэгжээгүй	ЕС-ын багц	ИНЕГ-ын хөрөнгө оруулалт	3 151.5	155.1
		МШХХТГ, ҮХШХ-ноос хэрэгжүүлэх арга хэмжээ	МШХХТГ, ҮХШХ-ноос хэрэгжүүлэх арга хэмжээ	2 050.0	-
			Цагдаагийн тасгийн барилга	60.0	-
			Хөдөлмөрийн төв биржийн барилга	2 000.0	-
			ЭМОТ-ийн зураг төсөө, ТЭЗҮ	300.0	-
			Гүүр, ДШС-ний өргөтгөл, Нийслэлийн хорооллын цэвэр усны шугам, бүс нутгийн чанартай хатуу хучилттай авто зам	2 161.5	-
ЭБЭХЯ	Дулааны станцын шинэчлэл, дотоодын хөрөнгө оруулалт	1 400.0	-		


Тайлбар:

- 2009 онд хэрэгжүүлэхээр 29 арга хэмжээнд төсөвлөгдсөн 8.5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг аваагүй буюу хэрэгжээгүй, тухайн онд санхүүжилтээ авч ашиглалтад оруулах гэрээтэй боловч чадаагүй 28.8 тэрбум төгрөгийн ажил байжээ.
- 2010 оны урьдчилсан гүйцэтгэлээс үзэхэд ойролцоогоор 20 орчим барилга, байгууламж зохих хугацаандаа ашиглалтад ороогүй, төлөвлөгөөний дагуу хэрэгжих 8.9 тэрбум төгрөгийн ажил, үйлчилгээнд зориулагдсан хөрөнгө ашиглагдаагүй буюу хэрэгжээгүй байна.

1.17 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний ТЭЗҮ, зураг төсвийг үнэлж шалгах байгууллага алга байна.

1.18 Зураг төсөв нь мэргэжлийн байгууллагаар хянагдаагүй төсөл, арга хэмжээг төсвийн хөрөнгө оруулалтад оруулж, төлөвлөх явдал байна.

1.19 Урьдчилсан судалгаа дутмаг, төлөвлөлтийн үндэслэл тодорхой бус байгаа нь тухайн төслийн үр ашгийг урьдчилан харах, хооронд нь жишиж ач холбогдлоор нь эрэмбэлэх боломжийг олгохгүй байна.



1.20 2010 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 1651 тендер зарлагдсаны 87.3 хувь буюу 463,3 тэрбум төгрөгийн худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг НТШ-ын аргаар, 1.4 хувь буюу 7.3 тэрбум төгрөгийн худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг хязгаарлагдмал, 6.7 хувь буюу 35.7 тэрбум төгрөгийн худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг харьцуулалтын, 4.6 хувь буюу 24,2 тэрбум төгрөгийн худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг шууд гэрээ байгуулах аргаар сонгон шалгаруулжээ.

1.21 2010 оны хөрөнгө оруулалтын зарим төсөл, арга хэмжээ хөрөнгө оруулалтын бус халамжийн болон ЖДҮ-ийг хөгжүүлэх арга хэмжээ, урсгал зардлыг санхүүжүүлэхэд зарцуулагдсан байна. Жишээлбэл, НХХС-ын багцын нийт хөрөнгө оруулалтын 2.9 хувь буюу 1089.5 сая төгрөгийн үнэ бүхий 1150 гэрийг нэн ядуу болон нийгмийн эмзэг бүлгийн иргэд, өрх толгойлсон эмэгтэйчүүдэд олгожээ. *Хүснэгтээр харуулбал,*

(сая төгрөгөөр)

д/д	Аймаг, дүүргийн нэр	Нийлүүлэгч компаний нэр	Гэрийн тоо	Гэрээний дүн
1	Архангай аймаг		297	225.0
2	Булган аймаг	“Дуган хад резорт” ХХК, “Цуулбар өргөө” ХХК	120	97.4
3	Говьсүмбэр аймаг	“Замтын далан” ХХК	20	20.0
4	Дархан-уул аймаг		49	49.0
5	Дорноговь аймаг	“Замтын далан” ХХК	30	30.0
6	Төв аймаг	“Их хүрхрээ” ХХК	70	60.0
7	Увс аймаг	“Увс-Зэлговь” ХХК, “Ойн найз” ХХК, “Сэтгэмж урлахуй” ХХК	277	249.9
8	УБ, Баянгол дүүрэг	“Тоб” ХХК	125	196.5
9	УБ, Баянзүрх дүүрэг	“Богд-Өргөө” ХХК	128	108.8
10	УБ, Налайх дүүрэг	“Богд-Өргөө” ХХК, “Өлзийт гэр” ХХК	34	52.9
Нийт дүн			1150	1 089.5

1.22 Зарим ТЕЗ ТБОНӨХБАҮХАТХ-ийн 21.1³ дүгээр заалтыг зөрчин ХАА-ны тендерийн урилга болон үр дүнг СЯ-ны цахим хуудсанд нийтлээгүй байна.

ТЕЗ-ын нэр	Тендерийн урилгыг вэбсайтад байрлуулсан эсэх	Тендер шалгаруулалтын үр дүнг цахим хуудсанд нийтэлсэн эсэх
ТШС	Ажлын албанд зохион байгуулсан тендерийн урилгыг нийтлээгүй	СЯ-ны ХАА-ны цахим хуудаст 2010 онд тендер шалгаруулалтын үр дүнг нийтлээгүй байна.
ШС	2010 онд салбарын хэмжээнд нийт 20 тендерийн урилга нийтлэхээс 14 тендерийн урилга нийтэлсэн	17 бараа, ажил, үйлчилгээний тендер шалгаруулалтын үр дүнг нийтлээгүй байна.
ЗГХЭГ	Бүрэн нийтэлсэн	СЯ-ны ХАА-ны цахим хуудаст 2010 онд тендер шалгаруулалтын үр дүнг нийтлээгүй байна
БХЯ	Бүрэн нийтэлсэн	СЯ-ны ХАА-ны цахим хуудаст 2010 онд тендер шалгаруулалтын үр дүнг нийтлээгүй байна
СС	2010 онд зарлагдсан вэбсайтад байрлуулах босго үнэ давсан тендер шалгаруулалтын урилгыг нийтлээгүй.	СС, ҮТЕГ үр дүнг огт нийтлээгүй бөгөөд харин УГЕГ нэг үр дүнг нийтлээгүй байна
ЕС	Босго үнэ давсан 31 тендер шалгаруулалтаас 10 тендерийн урилгыг нийтлээгүй.	Вэб сайтад нийтэлсэн 21 тендер шалгаруулалтын урилгын 4 тендерийн үр дүнг нийтлээгүй
БСШУС	Нийт 90 урилга тавихаас 63 урилга байгаа бөгөөд 27 урилгыг вэб хуудсанд тавиагүй	6 тендер шалгаруулалтын үр дүнг оруулаагүй
НХХС	Бүрэн нийтэлсэн	2 тендер шалгаруулалтын үр дүнг нийтлээгүй байна.
ХХААХҮС	Бүрэн нийтэлсэн	8 тендер шалгаруулалтын үр дүнг оруулаагүй
ЭБЭХС	Бүрэн нийтэлсэн	Цахим хуудаст нийтэлсэн 2 урилгын үр дүн нийтлэгдээгүй байна.
ЭМС	Бүрэн нийтэлсэн	8 тендер шалгаруулалтын үр дүнг оруулаагүй.

1.23 Автозамын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж аймаг, орон нутагт 47, УБ-т 139, нийт 186, барилгын ажил эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж аймаг, орон нутагт 417, УБ-т 1500, нийт 1917 байна. Харин барилга угсралт болон автозамын ажлыг бүрэн хэмжээнд гүйцэтгэх хүчин чадалтай аж ахуйн нэгж харьцангуй цөөхөн байна.

1.24 2010 оны хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнээс 11.6 тэрбум төгрөгийн 21 ажил огт хийгдээгүй, 34.1 тэрбум төгрөгийн 62 ажил дутуу хийгджээ. (ТЕЗ-аар хавсралт № 2-т харуулав)

³ ТБОНӨХБАҮХАТХ-ийн 21.1-д “Худалдан авах ажиллагааны тендерийн урилга болон үр дүнг цахим хуудсанд нийтэлж байх”

Бүлэг 2: Төрийн зарим байгууллага, гадаад харилцаа, хууль хүчний байгууллагын хөрөнгө оруулалтын хэрэгжилт

2.1 2010 оны Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар УИХ-ын тамгын газар, АТГ, ҮХЦ, ШЕЗ, УДШЕШ, УЕПГ, ЕС, ТШС, ШС, ЗГХЭГ, ГХС, БХС, СС, ХЗДХС зэрэг ТЭЗ-дын улсын төсвийн хөрөнгөөр санхүүжигдэх хөрөнгө оруулалтыг 88 917.6 сая төгрөгөөр баталжээ.

Зарим төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг тооцохдоо ТЭЗҮ болон зураг төслийг үндэслээгүй байна

2.2 Улсын төсвөөс санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын зарим төсөл, арга хэмжээг урьдчилан тооцож төлөвлөөгүй, төсөвт өртгийг дутуу тооцсон байна.Тухайлбал,

- *СХЗГ-т “шинжилгээний хайлах зуух нийлүүлэх, суурилуулах” тендерийн жишиг бичиг баримтад төсөвт өртгийг дутуу тооцоолсноос 127.0 сая төгрөгөөр нэмж санхүүжүүлсэн;*
- *Алтанбулаг худалдааны чөлөөт бүсийн төлөвлөгөөнд тусгагдаагүй зураг төслийг 69.2 сая төгрөгөөр санхүүжүүлсэн;*
- *ШС-ын төсвийн багцаас зураг төсөл, ТЭЗҮ тодорхой бус 1.5 тэрбум төгрөгийн 12 төсөл, арга хэмжээг санхүүжүүлсэн байна.*

2.3 Зураг, төсвийг нарийвчилж хийгээгүй, холбогдох байгууллагаас зохих зөвшөөрлийг бүрэн аваагүйгээс төлөвлөсөн төсөл арга хэмжээ хугацаандаа хэрэгжих боломжгүй болж, төсөвт өртөгт нөлөөлөх асуудал гарч байна.Тухайлбал,

- *УБ хотын гаалийн нэг цэгийн үйлчилгээний барилга барих талбай УБТЗ-ын өмчлөлд байснаас шалтгаалж захиалагчид урьдчилан тооцоогүй нэмэлт ажил гарч гэрээнд заасан хугацаанд ашиглалтад ороогүй;*
- *Замын-Үүд дэх гаалийн газрын рентген төхөөрөмжийн зам талбайн 519.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажил олон улсын шилэн кабелин шугам дайрснаас шалтгаалан нэмэлт ажил гарч гэрээний хугацаанд бүрэн хэрэгжээгүй байна.*

2.4 ТШС-ын багцаас 2010 онд хөрөнгө оруулалтаар чөлөөт бүсүүдэд 4 360.4 сая төгрөгийн 9 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн боловч явцын дунд хасагджээ.Тухайлбал,

- *Цагаан нуур худалдааны чөлөөт бүсэд “Хил гаалийн хяналтын талбайн зураг төсөл боловсруулах”-д 60.0 сая, “Бүсийн доторхи 5 км замын зураг төсөл”-д 17.0 сая, “Конторын барилгын их засвар”-т 33.0 сая, нийт 110.0 сая төгрөг;*
- *Замын-Үүд эдийн засгийн чөлөөт бүсэд автомашин худалдан авахад 25.0 сая, ногоон байгууламж барихад 203.5 сая, нийт 228.5 сая төгрөг зарцуулахаар тус тус баталсан боловч хасагдсан байна.*

Зориулалтыг нь өөрчилсөн, зураг төсөөгүй, хэрэгжих боломжгүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ цөөнгүй байна

2.5 Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй, тусгагдсан боловч төсөл, арга хэмжээний зориулалтыг өөрчилсөн тохиолдол гарсан байна. Тухайлбал,

- ТШС-ын багцад Алтанбулаг худалдааны чөлөөт бүсэд “Борооны ус зайлуулах далан барих” (707.4 сая) ажил нь “Алтанбулаг” худалдааны чөлөөт бүсийн Хилийн болон мэргэжлийн ажлын албадын байр барих болж өөрчлөгдсөн (720.4 сая);
- Мөн тус чөлөөт бүсийн зураг төсөл, судалгааны ажлын үнэ 69.2 сая төгрөг (төлөвлөгөөнд тусгагдаагүй-)ийг шууд гэрээ байгуулан санхүүжүүлсэн;
- ЗГХЭГ-ын багцад Хөвсгөл аймагт багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэх зорилгоор 340.0 сая төгрөг батлагдсанаас 90 багт 3.5 сая, аймгийн төвийн 2 дугаар багийн конторын барилгын засварт 25.0 сая төгрөг тус тус зарцуулахаар өөрчилсөн;
- Дорнод аймагт “Найрамдал” паркийн тохиожлод 50.0 сая төгрөг батлагдсаныг аймгийн төвийн усан оргилуурыг тохижуулах төсөл болгон өөрчилсөн.

ХАА-ны аргыг журмын дагуу сонгоогүй байна

2.6 Улсын төсвийн хөрөнгөөр 2010 онд хэрэгжүүлэх зарим төсөл, арга хэмжээ, тоног төхөөрөмжийг худалдан авахдаа хуульд заасан журмын дагуу үнэлээгүй, тендерийн бичиг баримтад заасан шалгуур үзүүлэлтийг хангаагүй гүйцэтгэгчийг сонгосон байна.Тухайлбал,

- УТЕГ 82,1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй суудлын 3 автомашин худалдан авах гүйцэтгэгчийг сонгохдоо тендерийн бичиг баримтад заасан нөхцөлийг хангаагүй аж ахуйн нэгжийг шалгаруулжээ.

2.7 ХАА-ны төлөвлөгөөнд тусгагдсан зарим төсөл, арга хэмжээ, барилга байгууламж, тоног төхөөрөмжийн гүйцэтгэгчийг ТБОНӨХБАҮХАТХ-ийн 8.5⁴-т заасныг зөрчин сонгож шууд гэрээ байгуулсан байна.Тухайлбал,

- “Алтанбулаг худалдааны чөлөөт бүсийн хилийн болон мэргэжлийн албадын байр”-ыг барих гүйцэтгэгчийг тендер зарлалгүй сонгож гэрээ байгуулсан;
- Цөмийн энергийн газар нэг ижил төрлийн тавилга, тоног төхөөрөмж худалдан авах 76.6 сая төгрөгийг 4 хуваан харьцуулалтын арга хэрэглэсэн;
- “Алтанбулаг худалдааны чөлөөт бүсийн гадна усан хангамж” тендерт шалгарсан “Комфорт-Импекс”ХХК-тай 2010 оны 6 дугаар сарын 28-нд 2419.6 сая төгрөгийн гэрээ байгуулсан боловч ажил гүйцэтгэх явцад нэмэлт ажил гарснаар 451.7 сая төгрөгийн гэрээг нэмж байгуулсан нь

⁴ ТБОНӨХБАҮХАТХ-ийн 8.5-дбосго үнэд багтах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэгжлэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж, хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно.

ТБОНӨХБАҮХАТХ-ийн “Гэрээ шууд байгуулах тухай” 34.1.4⁵ дэх заалтыг зөрчиж 88.8 сая төгрөгийн илүү санхүүжилт олгосон;

- *Мөн Замын-Үүдийн эдийн засгийн чөлөөт бүсэд хил, гаалийн шалган нэвтрүүлэх боомтод авто тээврийн хэрэгслийг жинлэх 150 тонны даацтай хяналтын пүүг худалдан авах, суурилуулах ажлын тендерт “Эн Ай Ди Бу” ХХК 135.3 сая төгрөгийн тендерт шалгарсан ч уг төсөвт өртгийн зөрүү 64.6 сая төгрөгийг нэмж олгосон нь дээрх хуулийн заалтыг зөрчиж 44.4 сая төгрөгөөр илүү санхүүжигдсэн байна.*

2.8 Ийнхүү тендерт бага үнийн саналаар шалгарч гэрээ байгуулаад, дараа нь нэмэлт ажил нэрээр төсөвт өртгийг нэмэгдүүлэх явдал гарч байна.

2.10 ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу төсөл, арга хэмжээ, барилга байгууламж, тоног төхөөрөмж худалдан авах тендерийн бичиг баримтыг баталгаажуулаагүй, түүнийг архивын нэгж болгон хадгалаагүй зөрчил нийтлэг байна. Тухайлбал,

- *УТЕГ тендерийн бичиг баримтыг ТБОНӨХБАҮХАТХ-ийн 49.2⁶-т заасны дагуу бүрдүүлээгүй;*
- *УТЕГ-ын автомашин худалдан авах үнэлгээний хороо тендерийн бичиг баримтыг үдэж нэгтгэн эмхлээгүй, түүнд агуулагдах ёстой баримт бичгийг бүрдүүлээгүй;*
- *ТШС-ын ажлын албанаас зохион байгуулсан зарим тендерийн бичиг баримтын бүрдэл хангалтгүй, үнэлгээний хороодын дарга гишүүдийн гарын үсэг дутуу;*
- *ТШС, ШС, ЕТГ, МШХХТГ, БХЯ, Цөмийн энергийн газар тендерийн баримт бичгийг зохих ёсоор эмхэлж, цэгцлээгүй, архивлаагүй байна.*

2.11 Энэ нь тухайн тендерийн бичиг баримт анхны хувилбар буюу тендер оролцогч нарт худалдсан хувилбар мөн эсэхэд эргэлзээ төрүүлэх, түүнчлэн харьцуулан шалгахад хүндрэл учруулж байна.

2.12 ХЗДХС-ын багцын хүрээнд Төрийн тусгай албан хаагчийн эмнэлгийн барилга барих тендерт 9142.9 сая төгрөгөөр “Шинэ барилга” ХХК шалгарч гэрээг 2010 оны 12 дугаар сарын 10-нд байгуулсан байна. Тайлант онд тус эмнэлгийн барилгад 800.0 сая төгрөг зарцуулахаар баталсан тул банкнаас баталгаа гаргуулан санхүүжилтийг 100 хувь хийжээ.

2.13 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгээгүй зөрчил нилээд байна. Тухайлбал,

- *Цөмийн энергийн газар 317.8 сая төгрөгийн “Шингэн азот нэрэх машин” нийлүүлэх гэрээг 2010 оны 5 дугаар сарын 27-нд 4 сарын хугацаатай ”И Икс Ай Эм Эм” ХХК-тай байгуулсан боловч хэрэгжээгүй;*
- *ЦЕГ-т 50.0 сая төгрөгийн тусгай хэрэгсэл хугацаандаа нийлүүлэгдээгүй;*
- *МШХХТГ-т БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх “Мэдээлэл,*

⁵ ТБОНӨХБАҮХАТХ-ийн 34.1.4-д -нэмэлт ажлын өртөг нь анхны гэрээний үнийн 15 хувь болон энэ хуулийн 8.1.1-д заасан харьцуулалтын босго үнийн аль багаас хэтрээгүй нөхцөлд тендер шалгаруулалтаар худалдан авсан ажлын нэмэлт болон түүнтэй ижил төстэй ажлыг давтан хийх тохиолдолд дахин тендер шалгаруулалт явуулснаар илүү сайн санал ирэхгүй гэж үзсэн бол.

⁶ ТБОНӨХБАҮХАТХ-ийн 49.1-д Захиалагч худалдан авах ажиллагаа явуулсан тухай бүр тендер шалгаруулалтын хавтаст хэрэг бүрдүүлж архивын нэгж болгон хадгална.

холбооны үндсэн сүлжээний өргөтгөл, шинэчлэл" төслийн дотоод эх үүсвэрт 2.0 тэрбум төгрөг батлагдсан боловч уг төсөл хэрэгжээгүй;

- ҮХШХ 1.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий "Өндөр технологийн аж үйлдвэрийг хөгжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх" төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах арга хэмжээг эргэн төлөгдөх, хөнгөлөлттэй зээл олгох хэлбэрээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн боловч хугацаа алдаж тендер зарласнаас шалтгаалан хэрэгжээгүй.

2.14 Хөрөнгө оруулалтын зарим төсөл, арга хэмжээний эрхийг орон нутагт шилжүүлэхгүйгээр гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 45.2.2⁷-т заасныг зөрчжээ. Тухайлбал,

- Завхан аймгийн Улиастай суманд 500.0 сая төгрөгийн өртөгтэй хүүхэд залуучууд, иргэдийн соёл амралтын хүрээлэн байгуулах барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг орон нутагт шалгаруулах ёстой байтал ШС-ын ажлын алба захиалагчийн үүрэг гүйцэтгэж "Ган"ХХК-ийг шалгаруулсан нь бүрэн хэрэгжээгүй;
- Дундговь аймгийн Өлзийт сумын сургуулийн дотуур байрны өргөтгөлд 100.0 сая , мөн аймгийн эмнэлгийн барилгын өргөтгөлд 219.0 сая, Дархан-Уул аймгийн хүүхдийн соёл амралтын хүрээлэнгийн хөлбөмбөгийн талбайг шинэчлэхэд 100.0 сая, Өвөрхангай аймгийн хүүхэд залуучуудын парк байгуулахад 300.0 сая төгрөгийн тендерийг ШС-ын ажлын алба зохион байгуулж шалгаруулсан байна.

2.15 Зарим ТЕЗ гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаагүйгээс хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагыг хангаагүй, чанар муутай бараа, ажил үйлчилгээг худалдан авч, төсвийн хөрөнгийг үргүй зарцуулснаас гадна, гэрээний үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгчтэй хариуцлага тооцоогүй байна.Үүнд,

- Дундговь аймгийн Өндөршил сумын ЗДТГ-ын 86.0 сая төгрөгийн барилгын ажлыг чанаргүй гүйцэтгэснээс гэрээнд заасан хугацаанд ашиглалтад ороогүй, халаалт нь холбогдоогүй;
- Мөн аймгийн Эрдэнэдалай сумын ЗДТГ-ын барилгын их засварт олгосон 55.0 сая төгрөгийн ажлыг дутуу хийснээс зарим өрөө, тасалгааны халаалт, цахилгааны монтаж дутуу, чанар муутай хийгдсэн;
- Орхон аймгийн Хүүхэд залуучуудын ордны 520.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй барилгыг 2010 онд ашиглалтад оруулах ёстой (2 удаагийн нэмэлт гэрээгээр сунгасан) боловч дуусаагүй байхад гүйцэтгэгчтэй хариуцлага тооцоогүй;
- Архангай аймгийн Өлзийт сумын Байшир багийг тохижуулахад 20.0 сая төгрөг батлагдсан боловч гэрээт хугацаанаас 47 хоног хэтэрсэнд хариуцлага тооцоогүй;
- Булган аймгийн хүүхдийн төлөө хэлтсийн барилгын их засварт 45.0 сая төгрөг олгосон боловч 4 сараар хугацаа хоцорсонд хариуцлага тооцоогүй;
- Ховд аймгийн Хүүхэд залуучуудын паркийг байгуулахад 3.2 тэрбум

⁷ ТБОНӨХБАҮХАТХ-ийн 45.2.2-т "төрийн захиргааны төв байгууллага нь ЗГ-ын гишүүний эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын хэрэгцээнд худалдан авах 200,0 саяас дээш төгрөгийн өртөг бүхий бараа, үйлчилгээ, 500,0 саяас дээш төгрөгийн өртөг бүхий ажлын хувьд", мөн хуулийн 45.2.3-т "энэ хуулийн 45.2.2-т заасан агентлаг, байгууллага, аймаг, нийслэлийн ЗДТГ 100,0-200,0 сая хүртэл төгрөгийн өртөг бүхий бараа, үйлчилгээ, 150,0-500,0 сая хүртэл төгрөгийн өртөг бүхий ажлын хувьд" захиалагч байх.

батлагдсан боловч газар доорх ажилд нэмж 800.0 мянган төгрөг зарцуулсан, гүйцэтгэгчийг оройтож шалгаруулснаас төлөвлөсөн хугацаанд ашиглалтад ороогүй, гүйцэтгэл 30 хувьтай байна.

Чанар муутай техник хэрэгсэл худалдан авч, хөрөнгө оруулалтын бус шинж чанартай арга хэмжээг санхүүжүүлж байна

2.16 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хуучин, хүчин чадал муу техник хэрэгсэл авч байгаа нь тухайн хөрөнгө оруулалтын ашиглалтын хугацааг богиносгож, үр өгөөжийг бууруулж байна. Тухайлбал,

- *УТЕГ нь ТӨХ-ны 2010 оны 151 дүгээр тогтоолоор Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар аймаг, дүүргийн Татварын хэлтсүүдэд Ланд крузер 80 болон 100 маркийн автомашинуудыг 252.0 сая төгрөгт багтаан худалдан авах зөвшөөрөл олгосны дагуу 1994-1999 онд үйлдвэрлэгдсэн 7 ширхэг Ланд крузер 80, Ланд Крузер 100 маркын автомашинуудыг 193.7 сая төгрөгөөр худалдаж авсан байна. Эдгээр машинууд нь дунджаар 150000 км-ын дундаж гүйлттэй, 15 жилийн дундаж насжилттай байна.*

2.17 Хөрөнгө оруулалтын бус шинж чанартай төсөл, арга хэмжээнд багагүй хэмжээний хөрөнгө зарцуулжээ. Тухайлбал,

- *“МШХХТГ-т суурин холбооны үйлчилгээний чанарыг сайжруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх” нэрээр МЦХ ХХК-ийн урсгал зардалд (цалин хөлс, холбооны зардал) 100.0 сая төгрөг зарцуулсан;*
- *ШС-ын ажлын албанаас Дархан-Уул аймагт залуу гэр бүлд зориулсан сургалт зохион байгуулахад 10.0 сая, амьдралын боломж тааруу залуусыг сургалтад хамруулахад 5.0 сая, иргэний боловсролд зориулсан хөтөлбөр хэрэгжүүлэхэд 15,0 сая, нийт 30,0 сая төгрөгийн төсөл хэрэгжүүлсэн;*
- *Мөн аймагт ЖДҮ-ийг дэмжихэд 302.0 сая төгрөг зарцуулсан байна.*

2.18 Энэ бүгдээс үзэхэд СС-ын 2010 оны 135 дугаар тушаалаар батлагдсан журмын 2.1⁸-дахь заалтыг зөрчиж, төлөвлөгөөнд тусгаагүй, шаардлага багатай хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлж байна.

2.19 Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, тоног төхөөрөмжийг холбогдох байгууллагын данс бүртгэлд тусгаагүй зөрчил гарч байна. Тухайлбал;

- *Алтанбулаг худалдааны чөлөөт бүс, Замын-Үүд эдийн засгийн чөлөөт бүсэд хийгдсэн хөрөнгө оруулалтыг улсын комиссын актаар хүлээн авсан боловч 4359.9 сая төгрөгийг тухайн хоёр бүсийн данс бүртгэл, тайлан тэнцэлд тусгаагүй байна.*

⁶ 2.1 Шинээр баригдах барилга байгууламжийн техник-эдийн засгийн үндэслэл, үр ашгийн тооцоог харгалзаж үзэх. Нийгмийн шинж чанартай барилга байгууламжийн хувьд түүнийг барих зайлшгүй шаардлага, хэрэгцээ, зардлын тооцоо, зураг төсвийг үндэслэх”

Бүлэг 3 Дэд бүтцийн салбарын хөрөнгө оруулалтын хэрэгжилт

Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг нэмж баталсан ч хэрэгжилт хангалтгүй байна

3.1 ЗТБХБС-ын төсвийн багцад 2010 онд улсын төсвөөс 193.0 тэрбум төгрөгийн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 157.5 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдсэнээс авто замд 66.8, барилга хот байгуулалтад 20.2, ИНЕГ-т 12.3, тээврийн салбарт 0.7 хувь нь тус тус зарцуулагдсан байна.

ЗТБХБЯ-ны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хянаж баталсныг хүснэгтээр харуулбал, (тэрбум төгрөгөөр)

Төсөл, арга хэмжээний хэрэгжүүлэгч	Төсөвт өртөг	Тайлант оны хөрөнгө оруулалт			Төсвийн тодотгол		
		Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хэрэгжээгүй дүн	Яамны санал	СЯ хянасан	УИХ баталсан
2	3	4	5	6	7	8	9
ЗТБХБЯ	949.9	193.0	157.5	35.5	52.9	-26.8	41.6
Нэмэгдэж	тоо				33	11	105
	дүн				72.6	43.7	76.1
Хасагдаж	тоо				-11	-25	-22
	дүн				-10.4	-93.5	-22.4
Авто зам	790.9	131.9	105.1	26.7	36.8	-30.2	38.5
Тээвэр	1.4	1.2	1.2	0.02	-0.02	-0.05	-
ИНЕГ	54.3	24.3	19.3	4.9	12.8	-2.9	-6.6
Барилга, хот байгуулалт	103.2	35.6	31.8	3.8	3.5	6.4	9.7

3.2 Хүснэгтээс үзэхэд төсвийн тодотголоор хөрөнгө оруулалтад 41.6 тэрбум төгрөг нэмж батлагдсан боловч хэрэгжээгүй төсөл, арга хэмжээний дүн 35.5 тэрбум төгрөг байна.

3.3 МУ-ын 2010 оны төсвийн тухай хуулиар ЭБЭХС-ын төсвийн багцад хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн төсөв 52.2 тэрбум төгрөгөөр батлагдсанаас 46.7 тэрбум төгрөгийг зарцуулж, гүйцэтгэл 89.5 хувьтай байна.

3.4 Төсвийн тодотголоор ЭБЭХЯ-ны санал дээр 5 төсөл, арга хэмжээний 5.2 тэрбум төгрөг нэмж батлагдсан байна. Төсвийн тодотголоор нэмэгдсэн төсөл, арга хэмжээг хүснэгтээр харуулбал,

(сая төгрөгөөр)

№	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	2010 онд батлагдсан	Гэрээний дүн
1	Дулааны станц, ДШС-ний шинэчлэл (Хөвсгөл)	14 000.0	500.0	13 922.5
2	Дулааны 6 "Г" 990 м*2, 400 мм-ийн шугамыг 500 мм болгон өргөтгөж шинэчлэх (УБ)	1 570.0	471.0	1 518.0
3	Мөрөн-Могойн голын 110кВ-ын ЦДАШ, дэд станцын зураг, барилга угсралтын ажил (Хөвсгөл)	8 120.0	3 120.0	
4	Сагсаагийн даваа-Хайчийн айл өрхүүд 0.4 кВ-ын 4.0 км ЦДАШ, дэд станц (Хөвсгөл, Хатгал)	36.0	36.0	36.0
5	Сайншандын аж үйлдвэрийн цогцолбор орчмын талбайд явуулах агаарын геофизикийн судалгаа, хайгуул	2 342.1	1 075.1	2 342.0
Нийт дүн		40 068.1	5 202.1	31 741.1

3.5 2010 онд улсын төсвийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ерөнхий төлөвлөгөөгөөр ЗТБХБС-ын багцад батлагдсан 61 төсөл арга хэмжээнээс зураг төсөвгүй 21, зээлийн гэрээгүй 2, ЭБЭХС-ын багцад шинээр хэрэгжих 50 төсөл арга хэмжээний 68 хувь буюу 34-т ТЭЗҮ боловсруулаагүй байна.

3.6 2010 онд ЭБЭХЯ-нд батлагдсан доорх төсөл, арга хэмжээ нь өөрчлөгдсөнөөс шалтгаалан хэрэгжээгүй байна.Үүнд:

Төсөл, арга хэмжээний нэр	Хэрэгжээгүй шалтгаан
Газрын тосны боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ боловсруулах	1 000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 2010 онд 300.0 сая төгрөг батлагдсан.2011 онд төсөвт өртгийг нэмэгдүүлсний дараагаар тендер зарлахаар тогтсон.
Хөвсгөл аймгийн Мөрөн-Могойн голын 110 кВ-ын ЦДАШ, дэд станцын зураг, барилга угсралтын ажил	Төсөвт өртөг төсвийн тодотголоор 8 120.0 сая төгрөг болж өөрчлөгдсөн.
Сүхбаатар аймгийн Дулааны станц, дулааны шугам сүлжээний шинэчлэлийн ажил	Тендерийн үнэлгээний хороог байгуулсан боловч БНСУ-ын хөрөнгөөр барихаар шийдвэрлэсэн

3.7 ЗТБХБЯ-нд хэрэгжиж буй “Нийслэл хотын хүнсний найдвартай байдлыг хангах орон нутгийн тээврийн дэд бүтцийг хөгжүүлэх төсөл”, “Уньт-Тариалангийн чиглэлд хатуу хучилттай авто зам барих” төслийн зээлийн гэрээ УИХ-аар батлагдаагүй байхад хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан нь нийт ХАА-ны 32.8 хувь байна.

3.8 Мандалговь-Даланзадгад чиглэлийн 163 км, Арвайхээр-Баянхонгорын чиглэлийн 107 км хатуу хучилттай автозамын нээлттэй тендерийг 2 удаа, хязгаарлагдмал тендерийг нэг удаа зарласан боловч шаардлага хангасан материал ирээгүй учир “Шинжан инженеринг констракшн групп”-тэй 2010.9.28-нд, “Жансуй Жин Жиан” ХХК-тай 2010.10.11-нд тус тус шууд гэрээ байгуулсан байна.

3.9 ЗТБХБЯ-ны нийт ХАА-ны 53.5 хувийг хуулийн хугацаанд зарлаагүй нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 46.1.8⁹-дахь заалтыг зөрчиж, хөрөнгө оруулалтын арга хэмжээг хугацаанд нь хэрэгжүүлэх боломжийг алдагдуулахад хүргэжээ.

3.10 ЗТБХБЯ нь ИНЕГ-ын ХАА-г тайландаа нэгтгээгүй, СС-ын багцад батлагдсан 16 төсөл, арга хэмжээний ТЭЗҮ болон зураг төсвийг бүртгэлд тусгаагүй байна.

3.11 ЗТБХБЯ-ны үнэлгээний хороонд орсон газрын дарга, мэргэжилтнүүдийг түүвэрлэн үзүүлбэл;

№	Албан тушаал	Оролцсон байдал			
		Нийт	Дарга	НБД	Гишүүн
1	СХОГ-ын дарга	4	2	2	
2	СХОГ-ын ерөнхий ня-боогч	14	1		13
3	СХОГ-ын хөрөнгө оруулалтын мэргэжилтэн	10			10
4	СХОГ-ын ХАА-ны мэргэжилтэн	13		3	10
5	ЗТБГ-ын дарга	4	3		1
6	ЗТБГ-ын орлогч дарга	4	4		
7	БОСНААБГ-ын дарга	10	10		

⁹ ТБОНӨХБАҮХАТХ-ийн 46.1.8⁹-д “барилга, зам инженерийн шугам сүлжээ зэрэг тодорхой улиралд гүйцэтгэх онцлог шинж чанартай бараа, ажил үйлчилгээг худалдан авах ажиллагааг тухайн жилийн 1 сарын 15-ны дотор эхлүүлэх”

8	ХШҮГ-ын орлогч дарга	2	1		1	3.12 Тухайн жилд баталсан үнэлгээний хорооны бүрэлдэхүүний (77 үнэлгээний хорооноос)
9	ХШҮГ-ын мэргэжилтэн	5			5	
10	АЗГ-ын орлогч дарга	13	10	3		
11	АЗГ-ын хэлтсийн дарга	11	5	1	5	

87.7 хувьд яамны ажилтнууд оролцож ЗТБХБС-ын 14 дүгээр тушаалын 1¹⁰-д заасныг зөрчжээ.

Төлөвлөсөн төсөл, арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байна

3.13 ЗТБХБЯ 2010 онд ашиглалтад оруулахаар төлөвлөсөн хатуу хучилттай автозамын ажлын дийлэнх буюу 700.7 км, гүүрийн ажлын 47.5 хувь буюу 544.1 у/м, бохир усны шугамын 1.78 км ажлыг тус тус дутуу хийжээ.

Төсөл, арга хэмжээний төрөл		Хатуу хучилттай автозам (км)	Гүүр у/м	Бохир усны шугам (км)	Цэвэр усны шугам (км)	Дулааны шугам (км)	Цахилгааны кабель шугам (км)
Төсөл, арга хэмжээ тоогоор	төлөвлөсөн	29	6	6	9	5	1
	гүйцэтгэл	13	3	4	9	5	1
	дутуу	16	3	2			
Гүйцэтгэсэн хэмжээ	төлөвлөсөн	971.0	1.146.38	11.46	36.9	5.8	1.105.0
	гүйцэтгэл	270.3	602.3	9.68	36.9	5.8	1.105.0
	дутуу	700.7	544.08	1.78			
	Хэрэгжилт%	27.8	52.5	84.8	100.0	100.0	100.0

3.14 ЗТБХБС-ын тушаалаар дуусаагүй төсөл арга хэмжээний ажлыг түргэтгэх, дуусгах шийдвэр гаргасан ч хэрэгжилт хангалтгүй байна.

3.15 Гэрээний хугацаа хэтэрсэн компаниудад 4 141.0 сая төгрөгийн алданги тооцсон боловч дөнгөж 52.1 хувийг санхүүжилтээс суутган тооцжээ.

3.16 Сайдын тушаалаар тендерт оролцох эрхийг нь хассан “Хурдны зам”, “Хотын зам” ХХК-иудыг ХАА-нд оролцуулан ажил гүйцэтгэх гэрээ байгуулжээ.

Гэрээт хугацаанд ажлаа дуусгаагүй, ашиглалтад оруулаагүй шалтгааныг дурдвал;

№	Объектын нэр	Хэрэгжээгүй шалтгаан
1	Өвөрхангай, Хархорин сумын инженерийн шугам сүлжээ, төвлөрсөн усан хангамжийн систем, цэвэрлэх байгууламжийн өргөтгөл, шинэчлэлт угсралтын ажил	ХАА-нд маргаан гарсан
2	УБ хотын БГД 3,4 дүгээр хорооллын 31-ийн 3 дугаар коллекторын Ф500 мм-ийн бохир усны шугамын өргөтгөл, шинэчлэлтийн ажил	Урьдчилсан хайгуулын ажил алдаатай хийгдсэнээс 20.1 сая төгрөгийн нэмэгдэл зардал гарсан
3	14 дүгээр хорооллын дулааны 12-Б магистраль шугамын угсралтын ажил	Дахин зураг, төсөв хийснээс 127.8 сая төгрөгийн нэмэгдэл зардал гарсан
4	Завхан аймгийн Нисэх буудлын хөөрч буух хатуу хучилттай зурвас, үерийн далангийн барилга	Угсралтын ажлын явцад технологийн өөрчлөлт гарснаас зурагт нэмэлт оруулах болсон
5	Дархан-Уул аймаг дахь “Зорчигч үйлчилгээний төв” авто вокзалын барилга	22.2 сая төгрөгийн гадна тохижилтын ажил хийгээгүй
6	АХБ-ны Эрдэнэт хотын гэр хорооллын усан хангамжийг сайжруулах ажлын насосны тоног төхөөрөмж нийлүүлэлт, суурилуулалтын ажил	Тендерийн баримт бичгийн боловсруулалт оройтсон
7	Баянхонгор, Алтай, Арвайхээр хотуудын гэр хорооллыг төвийн ус хангамж, ариутгах татуургын сүлжээнд холбох, ус хангамжийн эх үүсвэр, цэвэрлэх байгууламжийн шинэчлэлтийн БУ-ын ажил	Тендерийн баримт бичгийн боловсруулалт оройтсон
8	БЗД-ийн Чулуун овоотын амины орон сууцны гадна цэвэр,	Улсын комисс хүлээж аваагүй, хариуцах

¹⁰ МУ-ын 2010 оны төсвийн тухай хуулиар батлагдсан...хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаанд яамны бодлогын газрын дарга нар болон мэргэжилтнүүдийн оролцоог багасгаж зөвхөн нэг албан хаагчийг оролцуулах....

бохир усны шугамын ажил 850.2 сая төгрөг, гүйцэтгэгч “Меговат”, “Набсан” ХХК-дын түншлэл

эзэнгүй, тоногдсон

3.17 Барилга угсралтын ажлыг дууссанаар гүйцэтгэл гаргаж санхүүжилтийг бүрэн авсан байна. Үүнд:

Барилга угсралтын ажил		Гүйцэтгэгч компани	Санхүүжилт (сая төг)
ХУД-ийн нэгдүгээр хороонд баригдсан ТА3-ийн 36 айл		“Альянс-Тех” ХХК	33.9
Барилгын гаднах инженерийн шугам сүлжээний ажил	Говь-Алтай аймаг 40 айлын орон сууц	“Алс”ХХК	30.5
	Дорноговь аймаг 40 айлын орон сууц	“ТОБЭМ”ХХК	18.4
	Увс аймаг 40 айлын орон сууц	“Хүрд оргил”ХХК	35.2
	Сүхбаатар аймаг 40 айлын орон сууц	“Сэргэн мандалт констракшн” ХХК	73.9
	Булган аймаг 20 айлын орон сууц	“Эв констракшн” ХХК	34.0
УБ Баянголын амны шинэ хорооллын 1,2,3 дугаар ээлжийн ДШС-ний ажил		“Меговатт”, “Одкон холдинг” ХХК	138.0

Гадаадын зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн дотоодын эх үүсвэрийн ашиглалт хангалтгүй байна

3.18 ЗТБХБЯ-нд 2010 онд гадаадын зээлийн хөрөнгөөр санхүүжсэн 14 төсөл, арга хэмжээний төсвийн хөрөнгө оруулалтын дотоод эх үүсвэрийн ашиглалт 66.7 хувьтай байна.

3.19 Зээлийн төсөл, хөтөлбөрийн гүйцэтгэгч компаниудын гадаадаас ажиллах хүч авах зөвшөөрөл тухайн жилийн 4, 7 дугаар сард гарсан, гэрээт хугацаандаа ажлаа дуусгаагүй, ажлын гүйцэтгэл 36-82 хувьтай байна. Тухайлбал,

АХБ-ны зээлээр хэрэгжиж буй “Бүс нутгийн автозам хөгжүүлэх төсөл”-ийн:

- Сайншанд-Замын-Үүд чиглэлийн 131.2 км хатуу хучилттай зам (Гүйцэтгэгч “Чайна Жео инженеринг” ХХК);
- “Бүс нутгийн автозам хөгжүүлэх төсөл”-ийн Сайншанд-Замын-Үүд чиглэлийн 62 км хатуу хучилттай зам (Гүйцэтгэгч “Шингли инженеринг” ХХК);
- “Бүс нутгийн автозам хөгжүүлэх төсөл”-ийн Сайншанд-Замын-Үүд чиглэлийн 18.25 км хатуу хучилттай зам (Гүйцэтгэгч “Шингли инженеринг” ХХК); Сайншанд-Замын-Үүд чиглэлийн хатуу хучилттай замаас Эрдэнэ сум хүртэлх 15.5 км (Гүйцэтгэгч “Шингли инженеринг” ХХК) хатуу хучилттай зам.

3.20 Дээрх замыг барьж эхлээд 3-4 жил өнгөрч байгаа бөгөөд хугацааг 2-3 удаа сунгасан боловч өнөөг хүртэл дуусаагүй, гэрээний хариуцлага тооцоогүй байна.

Төсвийн хөрөнгөөр баригдаж буй автозамын ажлын гэрээний нөхцөл тодорхой бус, түүнд тавих хяналт хангалтгүй байна

3.21 Улсын төсвийн хөрөнгөөр баригдсан автозамын 51 төсөл, арга хэмжээний гүйцэтгэл 73.4 хувь байна.

Гэрээт хугацаанд ажлаа дуусгаагүй, он дамжин гүйцэтгэж байгаа автозамын барилгын үлдэгдэл ажлыг хүснэгтээр харуулбал,

Төслийн нэр, байршил	Гүйцэтгэгч байгууллага	Гэрээ дуусах хугацаа	Гэрээт ажлын үлдэгдэл %
Ховдын Булган-Үенч-Ховд чиглэлийн 40 км хатуу хучилттай авто зам	“Читай” ХХК	2010.09.30	30.5
Ховдын Булган-Үенч-Ховд чиглэлийн 40 км хатуу хучилттай авто зам	“Читай” ХХК	2010.10.30	67.5
Халзанбүргэдэй (Тариат)-Солонготын даваа чиглэлийн 100 км хатуу хучилттай авто зам (Архангай)	“ӨМӨЗО-ны 2 дугаар барилга” ХК	2010.11.01	63.3
Баянхонгор-Арвайхээрийн 27 км хатуу хучилттай авто зам (Баянхонгор)	“Төв АЗЗА” ХК	2010.10.30	30.8
Баянхонгор-Нарийнтээлийн 50 км хатуу хучилттай авто зам (Баянхонгор)	“УБ АЗЗА” ХК	2010.10.30	48.3
Баянхонгор-Нарийнтээлийн 50 км хатуу хучилттай авто зам (Баянхонгор)	“Насны зам” ХХК	2010.08.30	46.9
Мөрөн-Хатгалын 50.0 км хатуу хучилттай зам (Хөвсгөл)	“Арж капитал” ХХК	2010.10.20	54.3
Мөрөн-Хатгалын 48.8 км хатуу хучилттай зам (Хөвсгөл)	“Ялгуусан” ХХК	2010.10.20	81.1
Хануйн голын төмөр бетон гүүр-Халзан бүргэдэй чиглэлийн 65.0 км хатуу хучилттай зам /Катарын буцалтгүй тусламж (Архангай)	“Монроуд” ХХК	2010.10.30	12.3
Цэцэрлэг-Их тамир-Тосонцэнгэл чиглэлийн 53 км хайрган замыг хатуу хучилттай болгох	“Хурдны зам ХХК	2010.09.01	21.0

3.22 Дээрх замын ажлын хувьд гэрээ байгуулсан эхний 2 жилд хөрөнгийг бага хуваарилснаас ажил хойшилж, дараагийн жилүүдэд үнийн өсөлтөөс төсөвт өртөгтөө багтахгүй болсон, гадаадаас ажиллах хүч авахад хугацаа алдсан, машин механизмын хүчин чадал, гүйцэтгэгч, түншлэгч компаний гэрээний үүргийн болон ажлын зохион байгуулалт, хариуцлага хангалтгүй, захиалагчийн зүгээс асуудлыг шуурхай шийдвэрлээгүй зэрэг шалтгаанаар ажил саатаж байна.

3.23 2010 онд ЗТБХБЯ гүйцэтгэгчдээс төвлөрүүлсэн 1 069.4 сая төгрөгийн захиалагчийн хяналтын зардлыг АЗГ-т шилжүүлж 614.9 сая төгрөгийг хяналт тавихад зарцуулсан ба ажлын үр дүн хангалтгүй байхад талбайн хяналтын инженерүүдэд улирал, жилийн ажлын үр дүнгийн урамшуулал олгож байсан бөгөөд гүйцэтгэгчдэд хариуцлага тооцоогүй байна.

3.24 Харин зарим төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд захиалагчийн хяналтыг зөвлөх үйлчилгээний компаниар гүйцэтгүүлж буй нь гэрээний үүргийн биелэлтийг тооцох үр дүнтэй хэлбэр байж болох юм.

3.25 ЭБЭХС-ын 2010 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний нийт гэрээний 88 хувьд гэрээний үнийн дүнгээс алданги тооцохоор байгаа нь МУ-ын Иргэний хуулийн 232.6-д “...хугацаа хэтрүүлсэн тал нь хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,5 хувиас хэтрэхгүй хэмжээгээр төлөхөөр...” гэж заасныг зөрчжээ.

3.26 ЭБЭХЯ-наас дулааны улиралд гүйцэтгэх шаардлагатай, өвлийн ид ачааллын үед таслалт, залгалт хийх боломжгүй, зураг төсөв нь экспертизээр баталгаажуулаагүй зэрэг шалтгаанаар гүйцэтгэгчтэй байгуулсан 14 гэрээний хугацааг 1-2 удаа сунгасан боловч хугацаандаа ажил дуусаагүй байхад гүйцэтгэгчтэй хариуцлага тооцоогүй байна. Үүнд,

- Зуунмод хотын 4 дүгээр дунд сургууль, Халдвартын эмнэлгийн өргөтгөл, “Ирээдүй” цэцэрлэгийг газрын гүний дулааны нөөцийг ашиглан дулааны эрчим хүчээр хангах ажил. Гүйцэтгэгч “Мон-Угсралт” ХХК;
- УБ хотын Умард дэд станцын трансформатор, хаалттай хуваарилах байгууламжийн өргөтгөл, шинэчлэлт хийх ажил. Гүйцэтгэгч “Илч хангай” ХХК;
- УБ хотын төвд 35/06 кВ-ын дэд станц, газар доогуурх кабелийн ажил, гүйцэтгэгч “Хасуу Эрчим” ХХК;
- “Хайлааст” дэд станцаас Яргайт дэд станц хүртэл 35 кВ-ын 2 хэлхээт 9 км ЦДАШ барих ажил. “Тэнгэр уул” ХХК

3.27 ЭХГ-ын захиалагчийн албаны хувьд барилга угсралтын ажлын зарим гэрээнд ажил эхлэх, дуусах хугацааг журамлаагүйгээс гэрээний хариуцлага тооцоход хүндрэлтэй, техникийн комиссын акт нь дугааргүй, тендерийн баримт бичгийг эмхэлж, архивлах ажил хангалтгүй байлаа.

Хөрөнгийг ашиглагчид хүлээлгэн өгөөгүй, авлага, өглөгийн үлдэгдлийг баталгаажуулаагүй байна

3.28 ЗТБХБЯ болон ЭБЭХЯ 2010 оны төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээний санхүүжилтийн дөрөвний нэгээс их хувийг зөвхөн 12 дугаар сард гүйцэтгэгчид олгосон байна.

3.29 ЗТБХБЯ зураг төсөв боловсруулах 17 ажлын 932.7 сая төгрөгийг дуусаагүй үйлдвэрлэлийн бүртгэлд тусгаагүй, гүйцэтгэгч 39 байгууллагаас авах 9 048.1 сая төгрөгийн авлага, 129 байгууллагын 10 346.6 сая төгрөгийн барьцаа баталгааны болон бусад өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

3.30 ЭБЭХЯ хөрөнгө оруулалтын гэрээг дүгнэж, алданги тооцсон боловч тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, захиалагчийн алба, санхүү, хөрөнгө оруулалтын албадын мэдээлэл хоорондоо зөрүүтэй байлаа.

3.31 Улсын комисс ажиллаж ашиглалтад оруулсан 45 объектын 52.9 тэрбум төгрөг ЭХГ-ын дуусаагүй барилгын дансанд бүртгэлтэй байгаа нь СС-ын 135 дугаар тушаалаар батлагдсан журмын 3.23 дүгээр¹¹ заалтыг зөрчжээ.

¹¹ “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн барилга байгууламж, их засварын ажил, худалдан авсан тоног төхөөрөмжийг ашиглалтад хүлээн авсан гүйцэтгэлийн эцсийн дүнгээр тухайн төсөл хэрэгжсэн төсөвт байгууллагын санхүүд бүртгүүлэн, тайлан баланст нь тусгах арга хэмжээг Захиалагч байгууллага хариуцан гүйцэтгэнэ.”

Бүлэг 4. Нийгмийн салбарт улсын төсвөөс санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын хэрэгжилт

Зураг төсөв нь бэлэн болоогүй объект төлөвлөгдөж байна

4.1 Монгол Улсын 2010 оны төсвийн тухай хуулиар нийгмийн салбарт дараахь хөрөнгө оруулалт батлагджээ.

(тэрбум төгрөгөөр)

Салбар	“Зарлагын хязгаар батлах тухай” ЗГ-ын 2009 оны 220 дугаар тогтоолд	Яамны төсвийн төсөлд	Төсвийн тухай хуульд	Төсвийн тодотголд
БСШУ-ны салбар	50.0	96.5	54.0	75.4
НХХ-ийн салбар	0.4	21.4	38.3	38.3
ЭМ-ийн салбар	24.0	46.1	29.1	43.3

4.2 Төсвийн тодотголоор хөрөнгө оруулалтыг нэмж батлахдаа хэрэгжих хугацаа, төсөвт өртгийг тэр бүр бодитой тооцдоггүйгээс зураг төсөв гарах үед төсөвт өртөг өндөр гарч, түүнийг дараа дараагийн жилд хэсэгчилж батлах, жил бүр тухайн санхүүжилтэд тааруулан тендер зарлаж тус бүрд нь гэрээ байгуулах явдал гарсаар байна.Тухайлбал,

- Архангай аймгийн Батцэнгэл, Цэнхэр сумдын спорт заал, Хашаат сумын дотуур байрны барилгуудад төсвийн тодотголоор тус бүр 250 сая төгрөгийн төсөв баталж, 2010 онд хэрэгжүүлэхээр хуульд заасан боловч төсөвт өртөг нь хүрэлцэхгүй тул 2011 онд дамжсан;
- Төв аймгийн Бүрэн сумын хүүхдийн цэцэрлэгт 150.0 сая, Батсүмбэр сумын Цогт-Өндөр багийн 25 хүүхдийн цэцэрлэгийн барилгад 30.0 сая, Говь-Алтай аймгийн Баян-Уул сумын 640 хүүхдийн суудалтай сургуулийн барилгад 300.0 сая, Төгрөг сумын сургуулийн 160 хүүхдийн суудалтай өргөтгөлд 50.0 сая, Дарви сумын цэцэрлэгийн барилгад 100.0 сая, Ховд аймгийн Жаргалант сумын сургуулийн барилгад 110.0 сая, Дарви сумын сургуулийн өргөтгөлд 300.0 сая, Увс аймгийн Улаангом сумын Эрдэм оргил, Шинэ ирээдүй сургуулийн хичээлийн байрны өргөтгөлд 230.0 сая төгрөг тус тус баталж 2010 онд хэрэгжүүлэхээр заасан ч ажлын гүйцэтгэл 15-66 хувьтай;
- Завхан аймгийн Шилүүстэй сумын эмнэлгийн барилгад 500.0 сая төгрөг батлагдсан боловч төсөвт өртөг нь 660.0 сая төгрөг, Хэнтий аймгийн Өндөрхаан хотын уламжлалт анагаах ухааны эмнэлгийн барилгад 494.5 сая төгрөг батлагдсан ч төсөвт өртөг нь 679.1 сая төгрөг тус тус болж 2011 онд дамжих болжээ.

4.3 ЭМ-ийн салбарт нэгтгэн зарлах зарим төсөл, арга хэмжээний ажлыг дотор нь жижиглэж харьцуулалтын аргыг сонгосон зөрчил илэрлээ. Тухайлбал,

- ЗГ-ын VIII байрны 165.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй их засварын ажлыг хэд хэдэн багцад хувааж харьцуулалтын аргаар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан,
- Улсын хэмжээнд чихрийн шижин өвчинтэй тэмцэхэд зориулж 400.0 сая төгрөгийн тендерийг зарлахдаа тоног төхөөрөмжийг 5 багц болгон хязгаарагдмал тендер шалгаруулалтын аргыг сонгосон байна.

4.4 БСШУЯ барилга объектыг шинээр барих, өргөтгөх талаархи салбарын болон орон нутгийн засаг захиргаа, УИХ-ын гишүүдийн саналаас эхлэн улсын комиссын акт гарч ашиглалтад оруулах хүртэлх үзүүлэлтүүдийг багтаасан нэгдсэн мэдээллийн санг бий болгох ажлыг 2008 оноос хэрэгжүүлж байна.

Өмнөх онуудын төлөвлөлтийн зөрчил хөрөнгө оруулалтын цаашдын хэрэгжилтэд сөргөөр нөлөөлсөөр байна

4.5 БСШУЯ гэрээ цуцлагдсан гүйцэтгэгч нараас хийсэн ажил, олгосон санхүүжилтийн зөрүүг нэхэмжлэхдээ экспертизийн дүгнэлт гаргуулаагүй, экспертизийн дүгнэлтээр зөрүүг тогтоосон боловч нэхэмжилж аваагүй байна.Тухайлбал,

- "Монгени" сургуулийн өргөтгөл, спорт заалны барилгын гүйцэтгэгч "МБҮ" ХХК графикайн дагуу ажлаа гүйцэтгээгүй тул гэрээг цуцалж, "Зос трейд" ХХК-тай БУА-ыг 2010 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүлээлгэн өгөх 350.0 сая төгрөгийн гэрээг БСШУЯ байгуулсан ч ашиглалтад ороогүй;
- БСШУЯ-ны БЗА гэрээ цуцлагдсан "МБҮ" ХХК-ийн хийсэн ажил, олгосон санхүүжилтийн зөрүүд 50.0 сая төгрөг нэхэмжилсэн нь мэргэжлийн экспертизийн дүгнэлтээр баталгаажаагүй;
- Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын 320 хүүхдийн хичээлийн байр, спорт заалны барилгын гүйцэтгэгч "Дэлгэр интернэшнл" ХХК 2007 оны 8 дугаар сарын 15 -ны өдөр ашиглалтад өгөхөөр 585.0 сая, 2007 оны 8 дугаар сарын 21-ний өдөр спорт заалны хэмжээг томсгох 56.0 сая, хугацааг 2009 оны 8 дугаар сарын 15 хүртэл сунгаж, 275.4 сая төгрөгийн нэмэлт гэрээг тус тус байгуулсан;
- "Дэлгэр интернэйшнл" ХХК материалын үнийн зөрүүд 140.0 сая төгрөг нэхэмжилснийг УИХ-аас 21.0 сая төгрөг болгон баталсан байна. Үүнийг үлдсэн ажилд хүрэхгүй гэж үзэн спорт заалны БУА-ыг гүйцэтгэх боломжгүйгээ мэдэгдэж, гэрээ цуцлагдсан. Тус компани хичээлийн байрыг барьж улсын комисст хүлээлгэн өгсөн, спорт заалны суурь тавихдаа баганы тэнхлэг зөрсөн, хийсэн ажил нь авсан санхүүжилтээсээ 115 .0 сая төгрөгөөр дутуу болохыг мэргэжлийн экспертизээр тогтоосон боловч компаниас авч чадаагүй;
- Шинээр шалгарсан "Суварга Эв" ХХК спорт заалны суурийг шинэ зураг, төслийн дагуу алдааг залруулан 2010 онд ашиглалтад оруулах 275.0 сая төгрөгийн гэрээг Хэнтий аймгийн Засаг даргатай хийсэн боловч ашиглалтад ороогүй байна.

4.6 Барилга объектын төлөвлөлттэй холбоотой асуудлыг бүрэн шийдээгүй байхад хөрөнгө батлан барилгын ажлыг эхлүүлснээс хугацаандаа багтахгүй он дамжин сунжирч байна.Тухайлбал,

- 2008 оноос эхэлсэн Уламжлалт анагаах ухааны корпорацийн эмийн үйлдвэрийн барилга цахилгааны болон бохир усны техникийн нөхцөл удаа дараа өөрчлөлт орсноос цаг алдаж ашиглалтад ороогүй;
- БГД-ийн 1-4 дүгээр хорооны нутагт баригдаж буй 640 хүүхдийн суудалтай сургууль анх 2008 оноос 928 хүүхдийн суудалтай байхаар төлөвлөгдсөн ч олгосон газрын хэмжээнд тохируулан суудлыг тоог багасгаж, 2010 онд ажлаа эхэлсэн;
- СХД-ийн 38 дугаар цэцэрлэгийн барилгыг 2007 оноос эхэлсэн ч гадна цахилгааны эх үүсвэр шийдээгүйгээс ашиглалтад оруулаагүй;
- Ховд аймгийн Жаргалант сумын 320 хүүхдийн сургууль 2008 оноос төлөвлөгдсөн ч байршил өөрчлөгдсөнөөс цэвэр бохир усны сүлжээ, дэд өртөөний байрлал өөрчлөгдсөн; Ховд аймгийн төвийн цэвэр бохир усны сүлжээ ашиглалтад ороогүй, явцын дунд спорт заал нэмж барих болсон;
- СБД-ийн 16 дугаар хорооны цэцэрлэгийн барилгын газрын захирамж уулын бэлд, өндөр хүчдэлийн шугамын дор гарснаас цахилгааны техникийн нөхцөл өгөөгүй. дахин газрын захирамж гарсан;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн цэцэрлэгийн барилга 2010 онд ашиглалтад орох ёстой ч бохир ус зайлуулах техникийн нөхцөл нь хувийн орон сууцны шугаманд холбохоор гарсан тул түүнтэй тохиролцоход цаг алдсан, энэ хооронд ДШСГ-аас графикт зогсолт хийснээс дулаан өгөөгүй;
- БЗД-ийн 4, 7 дугаар хорооны цэцэрлэгийн барилгуудын газрын захирамж гараагүйн улмаас ажил удааширч 4,11 дүгээр хороонд цэцэрлэгийн барилга барихаар өөрчлөгдөж гэрээг 2010 оны 12 дугаар сарын 16-ны өдөр байгуулж тухайн оны санхүүжилтийг бүрэн олгосон ч ашиглалтад ороогүй;
- 1.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Ховд аймгийн Жаргалант суманд баригдсан 50 ортой төрөхийн барилга анх зураг, төсөвгүй улсын төсөвт тусгагдсаны улмаас зураг төсөв бэлэн болсны дараа төсөвт өртөгт болон гэрээний дүнд нэмэлт өөрчлөлт орсон;
- Булган аймгийн Баян-Агт сумын эмнэлгийн засварт 30.0 сая төгрөг батлагдсныг аймагт эрх шилжүүлж, зураг төсөв хийлгэснээр 66.5 сая төгрөг шаардлагатай болж, Дэлхийн зөн ОУБ-аас нэмэлт санхүүжилт хүссэн боловч уг зураг төсөл шаардлага хангаагүйгээс ажил эхлээгүй;
- Сэлэнгэ аймгийн Мандал сумын эмнэлгийн барилгын өргөтгөл дууссан ч шугам сүлжээн дээр барьсан учир улсын комисс хүлээж аваагүй байна.

4.7 Захиалагчийн зүгээс гүйцэтгэгчийг шалгаруулах тендерийг оройтож зарлах, санхүүжилтийг бүрэн авахын тулд хийгдээгүй барилгын ажилд бодит бус гүйцэтгэл, банкны баталгаа, бараа материалын худалдан авалтын тайлан гаргах, санхүүжилтийг оны эцэст гүйцэтгэгчид шилжүүлэх зэрэг зөрчил дутагдал арилахгүй байна. Тухайлбал,

- Хан-Уул дүүрэг дэх олимпийн хотхоны гадна инженерийн шугам сүлжээ, зам талбай тохижилт, автомашины зогсоолын 2.9 тэрбум төгрөгийн ажилд оны сүүлчээр гэрээ хийж, ажлын явц 60 хувьтай байхад санхүүжилтийг

бүрэн олгосон;

- Оны сүүлчээр гэрээ хийсэн БЗД-т баригдах сэтгэцийн эмгэг судлалын үндэсний төвийн барилгын ажилд 600.0 сая, ХУД-т баригдах 1000 хүний суудалтай спорт цогцолборт 103.0 сая төгрөгийг тус тус барилгын материал худалдан авсан гүйцэтгэл гаргаж, ХУД-ийн 300 ортой төрөхийн барилгын гүйцэтгэгч “Нийслэл Өргөө” ХХК-д 2600.7 сая төгрөгийн банкны баталгаа гарган шилжүүлсэн;
- Өвөрхангай аймгийн Арвайхээр хотын Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн паталогийн барилгын ажил бүрэн хийгдэж дууссан боловч одоог хүртэл улсын комисс хүлээж аваагүй ч гүйцэтгэгч “Сумпакс” ХХК-д санхүүжилтийг 100 хувь олгосон;
- Халдварт өвчин судлалын үндэсний төвийн цэвэрлэх байгууламжийн засварын ажилд 2010 онд 950.0 сая төгрөг төсвийн тодотголоор батлагджээ. “ЧММ” ХХК 2010 оны 12-р сарын 15-ны өдөр гэрээ байгуулж барилгын ажил оройтож эхэлсэн, санхүүжилтийг алдахгүйн үүднээс “ЧММ” ХХК-иар урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргуулан 863.6 сая төгрөгийг шилжүүлсэн;
- 2007 оноос эхэлсэн Завхан аймгийн Идэр сумын эмнэлгийн барилгын ажил 2010 онд дуусах ёстой ч дуусаагүй. Нийт 231.9 сая төгрөгийн санхүүжилт хийгдсний дотор 2010 оны 67.5 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгосон;
- Дорноговь аймгийн Замын-Үүдийн халдвартын эмнэлгийн барилгыг “Ган зосон констракшн” ХХК гүйцэтгэхээр санхүүжилтийг 100 хувь авсан боловч барилгын ажил одоо болтол дуусаагүй байна.

4.8 Анх тендерт бага үнийн саналтай орж шалгаран гэрээ байгуулчихаад дараа нь үнийн зөрүү нэхэмжлэх замаар төсөвт өртгийг нэмэгдүүлэх тохиолдол гарсаар байна.

- Алтай чуулгын БУА-ын төсөвт өртөг 2007 онд 1855.9 сая төгрөг байхад 2009 онд гүйцэтгэгч “Заг” ХХК-д үнийн зөрүүд 149.1 сая төгрөг олгож, дахин санхүүжилт нэхэмжилснээс 2009-2010 онд экспертиз ажиллуулж нийт авсан санхүүжилт, хийсэн ажлын хэмжээг тогтоож, 2606.1 сая төгрөг нэмж шаардлагатай гэж дүгнэлт гарсан байна. Зурагт өөрчлөлт ороогүй атал энэ нь 2007 онд зохиосон төсөвт өртгөөс хэт өндөр гарсан байна.
- Увс аймгийн техник технологийн “Улаангом” коллежийн БУА-ыг “Дэлгэр констракшн” ХХК 2008 онд дуусгахаар 2007 онд гэрээ хийсэн ч дуусгаагүй, 2009 онд үнийн зөрүүд батлагдсан 39.1 сая төгрөгийг хүрэхгүй гэж авалгүй, экспертиз хийлгэснээр 450.0 сая төгрөг 2011 оны төсөвт баталсан байна.
- Хэнтий аймгийн Бор Өндөр тосгоны сургуулийн дотуур байрны барилга 2010 онд хөрөнгө дутагдсан шалтгаанаар ажил удааширч үнийн зөрүү 61.0 сая төгрөгийг нэмж өгсөн байна.

4.9 Зарим ТЕЗ, аймгийн засаг дарга нар хөрөнгө оруулалтын зориулалтыг өөрчилсөн байна. Тухайлбал,

- Баянхонгор аймагт эмнэлгийн ажилчдын орон сууц барихад зориулан баталсан 477.0 сая төгрөгөөс аймгийн ЗД-ын захирамжаар 177.0 сая төгрөгийг эмнэлгийн ажилтнуудад зориулан орон сууц барьж буй барилгын компанид, бусад төрийн албан хаагч нарт 300.0 сая төгрөгийг бэлнээр

олгосон;

- “Хараагүй хүмүүсийн хөдөлмөр сургалтын үйлдвэрийн засвар”-т батлагдсан 22,4 сая төгрөгийг НХХС, СС-ын хамтарсан тушаалаар “НХХЯ-ны ажилтнуудын зуслангийн засвар, тохижилт” болгон өөрчилсөн;
- “Улсын асрамжийн газрын барилгын засварын зураг, төсөв”-ийн 20.0 сая, “ХХҮХ-ийн барилгын зураг, төсөл (УБ, ХУД)”-ийн 5.9 сая төгрөгийг нэгтгэн 25.9 сая төгрөгөөр НХХ-ийн салбарын зуслангийн зураг төсөв хийлгэсэн байна.

4.10 Улсын төсвөөс хөрөнгө оруулалтын бус шинж чанартай зардлыг санхүүжүүлсэн байна. Тухайлбал,

- ЭНЭШТ-д нярайн мэс заслын хэсэг шинээр байгуулахад зориулсан 350.0 сая төгрөгөөс их засварт 50.0 сая, нярайн тоног төхөөрөмжид 300.0 сая төгрөгийг зарцуулах ёстой ч 30.0 сая төгрөгийг нэг удаагийн хэрэгсэлд зарцуулсан;
- ЭМ-ийн салбарын их засварт 5.3 тэрбум төгрөг батлагдсаны дотор МУ-ын буцалтгүй тусламжаар БНАЛАУ-д барьсан Найрамдал эмнэлгийн засварт 300.0 сая төгрөг баталж зарцуулсан;
- БГ, БЗ, Налайх дүүрэг болон Архангай, Увс, Булган, Дорноговь, Говьсүмбэр, Төв, Дархан-Уул зэрэг 7 аймгийн иргэдэд 1 089.5 сая төгрөгийн үнэ бүхий иж бүрэн гэр 1150-г олгосон нь иргэдийн халамжийн үйлчилгээнд хамаарахаар байна.

4.11 Жич: Боловсрол, соёл, шинжлэх ухаан, эрүүл мэндийн салбарт 2010 онд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын үр дүнд хийсэн аудитын дүнг тусад нь тайлагнасан болно.

Бүлэг 5. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн салбарын хөрөнгө оруулалтын хэрэгжилт**Төсвийн тодотголоор нэмэгдсэн хөрөнгө оруулалтын зарим төсөл, арга хэмжээ салбарын бодлоготой уялдахгүй байна**

5.1. МУ-ын 2010 оны төсвийн тухай хуулиар БОАЖС-ын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд 3 385.9 сая төгрөг батлагдаж, аймаг, нийслэл, дүүрэгт 1 358.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын эрх шилжжээ.

5.2. ХХААХҮ-ийн салбарт хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд 36 085.7 сая төгрөг батлагдаж 34 381.0 сая төгрөгийн санхүүжилт олгогдсоноос 18 770.0 сая төгрөгийг “Атрын 3 дахь аян” хөтөлбөрийг хэрэгжүүлэх, инженерийн хийцтэй худаг, уст цэгийг шинээр гаргах, усалгаатай газар тариалангийн техник, тоног төхөөрөмж худалдан авахад зарцуулжээ.

5.3. 2010 онд ЖДҮ-ийг дэмжих зорилгоор 5 627.4 сая төгрөг зарцуулахаар хуульчлан батлагдсанаас 1480.0 сая төгрөгийг ХХААХҮ-ийн яамаар, 4 147.4 сая төгрөгийг орон нутгийн төрийн сангаар дамжуулан санхүүжүүлэхээр эрх шилжүүлэн зарцуулжээ.

5.4. Төсвийн тодотголоор БОАЖС-ын багцад хөрөнгө оруулалтын 8 төсөл, арга хэмжээнд 461.9 сая, ХХААХҮС-ын багцад 79 арга хэмжээнд 11 133.6 сая төгрөг нэмж батлагдсан нь зураг төсөвгүй байжээ.

5.5. Төсвийн тодотголоор нэмэгдсэн зарим төсөл, арга хэмжээний эрхийг аймаг, нийслэл, дүүрэгт шилжүүлсэн ч хэрэгжилт нь салбарын бодлоготой тэр бүр уялдахгүй байна. Тухайлбал,

- *Нийслэлийн Засаг дарга бөгөөд УБ хотын захирагчийн 2010 оны 26 дугаар захирамжаар ЧД-ийн Засаг даргад эрх шилжсэн “Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх бичил цэцэрлэг”-ийг тус дүүргийн 5 дугаар хорооны 4, 5 дугаар байрны дунд 46.5 сая, 3 дугаар хорооны 19, 29 дүгээр байрны дунд 49.4 сая, бүгд 95.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийсэн нь үндсэндээ биеийн тамир, тоглоомын талбай болсон байна.*

5.6. ХХААХҮС-ын багцад жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх зориулалтаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 5.6 тэрбум төгрөг төсвийн тодотголоор нэмж батлагдсаны 4.1 тэрбум төгрөг орон нутагт эрх шилжсэн нь салбарын хөрөнгө оруулалтын бодлоготой уялдахгүй байна. Тухайлбал,

- *Нийслэлийн засаг дарга бөгөөд УБ хотын захирагчийн 2010 оны 669 дүгээр захирамжаар Хан-Уул дүүрэгт 300.0 сая төгрөгийг 5 дугаар хорооны Үйлдвэр, үйлчилгээний төвийн гаднах тохижилт, ерөнхий боловсролын сургууль болон хороодод компьютер, техник хэрэгсэл худалдан авах, програм суулгах, эрүүл мэндийг дэмжих зорилгоор өрхийн эмнэлгийг унаажуулах, хүүхдийн клиник сувиллын гал тогооны төхөөрөмжийг шинэчлэх, соёлын төвийг хөгжмийн зэмсэг, техник хэрэгслэлээр хангах, цагдаагийн байгууллагад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор мотоцикл, техник хэрэгсэл худалдан авахад зарцуулсан;*

- Мөн оны ЧД-ийн ЗД-ын 26 дугаар захирамжаар 90.0 сая төгрөгийг 50 дугаар сургуулийн спорт, урлагийн заалны их засварт 13.0 сая, хороодын засаг дарга нарт 20 ширхэг компьютерийн үнэнд 24.0 сая, дүүргийн 12, 17, 18 дугаар хорооны өрхийн эмнэлгүүдэд тоног төхөөрөмж авахад 15.0 сая, бүгд 62.0 сая төгрөг зарцуулж, үлдэгдэл 38.0 сая төгрөгийг 2011 онд дүүргийн 4 дүгээр хорооны 15 дугаар байрны “Эвсэг нөхөд”, 6-р хорооны “Барилгачин”, 3 дугаар хорооны “Номин” СӨХ-дод орон сууцны гаднах, доторх засварын ажилд зарцуулахаар шийдвэрлэсэн;
- Хэнтий аймагт 60.0 сая төгрөгийг ЭМГ-т номны үнэнд 3.0 сая, ЗДТГ-ын засварын ажилд 4.0 сая, Өмнөдэлгэр суманд спорт заалны санхүүжилт 36.0 сая, тусламжид 1.0 сая, гэрэлтүүлэг, чимэглэлийн зардалд 12.0 сая төгрөгийг тус тус зарцуулжээ.

5.7. Хэнтий аймагт хуваарилагдсан 600.0 сая төгрөгөөс Хэрлэн суманд 150.0 сая, Бэрх суманд 40.0 сая болон сум бүрт 20.0 сая, бүгд 530.0 сая төгрөгийн зээлийг банкаар дамжуулалгүй хүүгүй олгожээ.

5.8. 2010 оны хөрөнгө оруулалтаар Өмнөговь аймгийн 10 сумын 150 малчин өрхөд тус бүр 2.0 сая төгрөгийн (50 толгой хээлтэгч) бог мал худалдан авахад 250.0 сая төгрөг зарцуулжээ.

Худалдан авах ажиллагааг зохих хууль тогтоомжийн дагуу зохион байгуулаагүй байна

5.9. БОАЖС-ын багцад 4 арга хэмжээний гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтаар шаардлага хангасан тендерийн баримт бичиг ирээгүйгээс нийлүүлэгч компанитай шууд гэрээ байгуулан техник, тоног төхөөрөмж худалдан авчээ.

5.10. “Арилжааны банктай дамжуулан зээлдүүлэх гэрээ байгуулах, санхүүжилт хийх тухай” ХХААХҮС-ын 2010 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн А/177 дугаар тушаалын 1-д “...Өвөрхангай аймагт ЖДҮ-ийг дэмжихэд зориулсан санхүүжилт 1280.0 сая төгрөгийг “ХААН” банкаар дамжуулан олгосугай” гэсний дагуу уг мөнгийг сарын 1 хувийн хүүтэй 3 жилийн хугацаатай тус банкинд олгосон байна.

5.11. Гэвч уг мөнгөнөөс 750.0 сая төгрөг тус яамны дансанд буцан орж, ТЭДС-гийн дансанд шилжсэн бөгөөд сан 303.9 сая төгрөгөөр ВТК-2032 төмсний иж бүрдэл, үрлүүр зэргийг тендер зарлалгүй шууд гэрээ байгуулж авчээ.

5.12. БОАЖС-ын багцаас орон нутагт эрх шилжсэн хөрөнгө оруулалтын зарим арга хэмжээг түүвэрлэн үзэхэд зураг төсөв нь экспертизээр хянагдаж батлагдаагүй төсвийг үндэслэн гүйцэтгэгчтэй шууд гэрээ байгуулсан байна.

5.13. “Чингис хааны нутгаар” аялал жуулчлал хөгжүүлэх хөтөлбөрт 335.0 сая төгрөг батлагдаж Хэнтий аймагт эрх нь шилжсэн бөгөөд уг хөтөлбөрийн хүрээнд “Монгол хатдын өргөө” цогцолборын зураг төсөв бэлэн болоогүй байхад гэрээ байгуулж ажил эхэлсэн байна.

5.14. ХХААХҮС-ын багцаас 2010 онд ЖДҮ-ийг дэмжих зорилгоор Сүхбаатар аймагт эрх нь шилжсэн хөрөнгө оруулалтын ажил зураг төсөвгүйн зэрэгцээ ХАА-г хууль

тогтоомжийн дагуу зохион байгуулсан эсэх нь тодорхойгүй, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн талаархи материал аймгийн ЗДТГ-ын холбогдох хэлтэст алга байна.

Хөрөнгө оруулалтын гэрээнд зарим гол нөхцөлийг тодорхой заахгүй байна

5.15. Зарим захиалагч байгууллага улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн гэрээг байгуулахдаа зохих хууль тогтоомж, заавар журмыг баримтлаагүй байна. Тухайлбал:

- *Усны газар 2010 онд улсын төсвийн санхүүжилтээр Дархан-Уул аймгийн Шарын гол сумын 99.5 сая, Сүхбаатар аймгийн төв Баруун-Урт хотын 109.9 сая, Дундговь аймгийн төв Мандалговь хотын 99.9 сая, Ховд аймгийн Манхан сумын 59.9 сая, Өмнөговь аймгийн Даланзадгад хотын 102.9 сая, бүгд 685.0 сая төгрөгийн усан хангамжийн нэмэгдэл эх үүсвэрийн зориулалттай газрын доорхи усны нарийвчилсан хайгуулын гидрогеологийн судалгааны 6 зөвлөх үйлчилгээний гэрээнд ажил гүйцэтгэх хугацааг заагаагүй, гэрээний ерөнхий, тусгай нөхцөл болон бусад баримт материал алга байна.*
- *УБ хот, Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэрт усны мониторингийн цооног өрөмдөх, тоноглох ажлыг гүйцэтгэх гэрээг байгуулсан огноо бичигдээгүй, уг ажлыг хийж дуусгах хугацаа нь тодорхойгүй байна.*

Өмнөх оны хөрөнгө оруулалтын гүйцэтгэл хангалтгүй байна

5.16. Өмнөх оны хөрөнгө оруулалтын ажил хэрэгжээгүй байхад санхүүжилтийг нь бүрэн олгох, нэмж санхүүжүүлэх зэрэг зөрчил гарсан байна. Тухайлбал, БОАЖЯ болон “Спейшл корпораци” ХХК-ийн хооронд “Үүлний явуулын радарын станц” 4 иж бүрдлийг 2009 оны 12 дугаар сарын 24-нөөс 2010 оны 2 дугаар сарын 24-ний хооронд 1 969.0 сая төгрөгөөр нийлүүлэх гэрээ хийж, төлбөрийг урьдчилан бүрэн хийсэн боловч өнөөг хүртэл хүлээн аваагүй нь дараахь шалтгаанаас болжээ. Үүнд:

- *ЦУОШГ-ын өмнө нь худалдан авч, зарим аймагт ашиглаж байгаа 724 XD маркийн явуулын радар машин нийлүүлэхээр тендерт шалгарсан атал 713 XD маркийн техник хэрэгсэл оруулж ирсэн;*
- *Радарын станцыг БОАЖЯ болон ЦУОШГ-аас томилогдсон ажлын хэсэг 2010 оны 6 дугаар сарын 10-ны өдөр хүлээн авах явцад мэдээ хүлээж авах антены суурь гэмтсэн, өргөгч домакрат, нум зэрэг нь тендерийн баримт бичигт заасан шаардлага хангаагүй;*
- *ЦУОШГ-ын даргын 2010 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 107 дугаар тушаалаар баталсан ажлын хэсэг мөн оны 10 дугаар сарын 22-ны өдөр “Спейшл корпораци” ХХК-ийн төлөөлөл болон үйлдвэрлэгч БНХАУ-ын компанийн 3 инженерийн хамт Морин уулын орчимд радар станцыг хүлээн авахаар туршилт хийж шалгахад уг станц хэвийн ажиллаагүй тул хүлээн аваагүй байна.*

5.17. СС-ын 2008 оны 58 дугаар тушаалаар баталсан журмын 3.5, 3.7-д зааснаар “барааны үнийн дүнгийн 30 хүртэл хувийн урьдчилгаа төлбөр”-ийг олгох ёстой байтал санхүүжилтээ бүрэн авсан байна.

5.18. ХХААХҮС-ын багцаас Хэнтий аймагт “Сүүний үйлдвэрийн тоног төхөөрөмж худалдан авах, үйлдвэрлэлийн барилга барих болон техник хэрэгсэл худалдан авах”

350.0 сая төгрөгийн гэрээг “Оргил констракшн” ХХК-тай байгуулж, 2009 онд 374.4 сая, 2010 онд 90.0 сая, бүгд 464.4 сая төгрөг зарцуулсан байна.

5.19. “Оргил констракшн” ХХК үйлдвэрийг 2010 оны 10 дугаар сарын 11-ний өдөр ашиглалтад өгсөн ч сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйл ажиллагаа жигдрээгүй, нягтлан бодох бүртгэл хөтлөөгүй, эхлэлтийн болон 2010 оны жилийн эцсийн тайлан тэнцэл гаргаагүй байна

Хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг үнэн зөв гаргаагүй байна

5.20. Улсын төсвийн хөрөнгөөр 2010 онд санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн тайланг зарим байгууллага үнэн зөв тайлагнаагүй байна. Тухайлбал,

- *БГД-ийн Энх тайван, Баруун ард Аюушийн (Гурвалжингийн тойрог Замын цагдаагийн постоос хойш Гэмтлийн эмнэлэг хүртэл) нийтийн эзэмшлийн зам талбайг зүлэгжүүлэх 43.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг “Бадмаараг гэрэл” ХХК хийж гүйцэтгэхээр гэрээ байгуулжээ. Ажлыг бүрэн гүйцэтгээгүй атал гүйцэтгэснээр тооцон зүлэгжүүлэх ажлыг хүлээлцсэн акт үйлдэж, гүйцэтгэгч болон захиалагч талын холбогдох хүмүүс гарын үсэг зурсан;*
- *Тус дүүргийн Энхтайвны өргөн чөлөө, Амарсанаагийн гудамжинд (Баруун 4-н замаас хойш хуучин Од кино театр хүртэл) мод сөөг тарих ажлыг “Мөнх ногоон амьдрал” ТББ 46.9 сая төгрөгөөр хийж гүйцэтгэхээр тендерт шалгарч, гэрээ байгуулан ажлаа гүйцэтгэжээ. Гэтэл гүйцэтгэлийг газар дээр шалгаж үзэхэд засмал замын баруун, зүүн гар талд тарьсан гэх 7548 хайлаас мод байхгүй байгаа нь хайс хамгаалалт хийлгүйгээр мод сөөг тарьсан энэ ажил үр дүнгүй болсон;*
- *Дээрх ажил бүрэн хийгдээгүй, мод сөөг нь ургаагүй байхад Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын 2011 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 14 дүгээр тушаалыг үндэслэн БГД-ийн санхүүгийн алба нийтийн эзэмшлийн хөрөнгөд бүртгэсэн байна.*

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлт хийж байна.Үүнд:

1. Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжид хамаарах зүйлсийг тодорхой болгох, хөрөнгө оруулалтын биш шинж чанартай зүйл болон зураг төсөвгүй, барих газар нь шийдэгдээгүй барилга байгууламжийг хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгахгүй байх талаар өмнө нь өгч байсан зөвлөмжүүдийг хэрэгжүүлээгүйгээс ийм төрлийн зөрчил арилахгүй давтагдсаар байна.
2. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд зураг, төсөвгүй, ТЭЗҮ, техникийн нөхцөл нь бэлэн биш төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийг төлөвлөж байгаа нь тогтсон журмыг алдагдуулж, төсөл, арга хэмжээ хугацаандаа хэрэгжихгүй, төлөвлөгөө тасрах, нэмэлт хөрөнгө шаардах сөрөг үр дагаварт хүргэж байна.
3. Зарим үнэлгээний хороод худалдан авах ажиллагааны аргыг буруу сонгосон, үр дүнг дутуу мэдээлсэн, буруу тайлагнасан, тендерийн бичиг баримтыг эмхэлж, цэгцэлж архивлаагүй байна.
4. 2010 онд дэд бүтцийн салбарт төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжээгүй байхад нийгмийн салбарын зарим төсөл, арга хэмжээ төлөвлөснөөс илүү хэрэгжсэн дүн гарсан байна.
5. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2010 онд санхүүжигдсэн төсөл, арга хэмжээнээс 45.6 тэрбум төгрөгийн 83 ажлын гүйцэтгэл дутуу болон хийгдээгүй зөрчил илэрсэн нь нийт хөрөнгө оруулалтын 8.9 хувь болж байна.
6. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний явцад тавих захиалагч, гүйцэтгэгч, зураг төсвийн байгууллагын хяналт хангалтгүй байна.
7. Гэрээний нөхцлөө биелүүлээгүй гүйцэтгэгч байгууллагатай тооцох хариуцлага сул байна.

Холбогдох байгууллагын санал



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/Факс: (976-51) 26-02-47, http://www.mof.gov.mn

2011-05-09 № 10/1874
танай _____-ны № 461 -Т

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОР Ч.РАДНАА ТАНАА

Аудитын тайланд санал
өгөх тухай

Улсын төсвийн хөрөнгөөр 2010 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаад дараахь саналыг хүргүүлж байна. Үүнд:

1. Тайлангийн дүгнэлтийн 1-д: Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжид хамаарах зүйлсийг тодорхой болгож, хөрөнгө оруулалтын биш чанартай зүйл, зураг төсөвгүй, барих газар нь шийдэгдээгүй барилга байгууламжийг хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгахгүй байх талаар өмнө нь өгч байсан зөвлөмжүүдийг хэрэгжүүлээгүйгээс ийм төрлийн зөрчил арилахгүй байгаа талаар дурджээ.

Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн харилцааг зохицуулж буй "Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай" хуулинд улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байшинд хамаарах зүйлсийг тусгасан заалт байдаггүй. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд хамаарах зүйлс хуульчлагдаж тодорхойлогдоогүй, тэдгээрт тавигдах шаардлага эрхзүйн хувьд тодорхой бус байдгаас дээрх зөрчил арилахгүй байна гэж үзэж байна.

Төсвийн тухай хуулиар хөрөнгө оруулалтын биш чанартай төсөл, арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталдаг нь худалдан авах ажиллагааг зохион байгуулах, төслийг хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, төсөл хэрэгжиж дууссаны дараа түүнийг улсын бүртгэлд тусгах зэрэгт ихээхэн хүндрэл учруулж байна.

Иймд Сангийн яамнаас шинээр боловсруулж, Улсын Их Хуралд өргөн бариад байгаа Төсвийн тухай хуулийн төсөлд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ барилга байшинд тавигдах шаардлагыг маш тодорхой тусгаж өгсөн.

Хуулийн төслийн 27 дугаар зүйлд "Төсвийн хөрөнгө оруулалт" гэсэн бүлэг шинээр нэмж оруулсан бөгөөд нийт 10 заалтаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөлд тавигдах тусгай шаардлагыг хуульчлахаар тусгаад байна.

Үүнд:

- 08 1323

27.1.1 тухайн салбарын хөгжлийн стратеги төлөвлөгөөнд тусгагдсан, нийгэм, эдийн засгийн тэргүүлэх ач холбогдол бүхий арга хэмжээг санал болгосон байх;

27.1.2 техник, эдийн засгийн үндэслэл болон бусад тооцоо судалгаагаар эдийн засгийн болон нийгмийн үр ашигтай байдлыг нь нотолсон байх;

27.1.3 нийт төсөвт өртөг нь 30.0 тэрбум төгрөгөөс дээш хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хувьд түүний техник, эдийн засгийн үндэслэлийг эдийн засгийн төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас судалж, үр ашигтай байдлыг нь тогтоосон байх;

27.1.4 концессийн гэрээгээр хэрэгжүүлэх боломжгүй;

27.1.5 шинээр баригдах барилга, байгууламжийн судалгаа, зураг төсөл, төсвийг батлуулсан, магадлал хийлгэсэн байх;

27.1.6 газрын зөвшөөрөл, техникийн нөхцөл бүрдсэн байх;

27.1.7 хөрөнгө оруулалтын үр дүнд бий болох үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр зэрэг холбогдох тооцоог хийж, төсөвт нөлөөлөх ачааллын талаар дүгнэлт гаргасан байх;

27.1.8 төсөл, арга хэмжээний нийт саналыг ач холбогдол, хэрэгжүүлэх дарааллаар нь эрэмбэлж, тухайн жилийн төсвийн хүрээний мэдэгдэл болон жилийн төсвийн хязгаарт багтсан хэсгийг тусгах;

27.1.9 хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг тухайн салбарын асуудал эрхэлсэн төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөвт харъяалуулах;

27.1.10 шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох хэсэг нь хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилснаас багагүй байх.

2. Тайлангийн дүгнэлтийн 2-д: *Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд зураг төсөвгүй, ТЭЗҮ, техникийн нөхцөл нь бэлэн биш төсөл, арга хэмжээ барилга байгууламжийг төлөвлөж байгаа нь тогтсон журмыг алдагдуулж, төсөл, арга хэмжээ хугацаандаа хэрэгжихгүй, төлөвлөгөө тасрах, нэмэлт хөрөнгө шаардагдах сөрөг үр дагаварт хүргэж байна гэсэн дүгнэлт өгчээ.*

Сангийн яам төсвийн ерөнхийлөн захирагч нараас ирүүлж буй төсвийн төсөлд зураг төсөвгүй, техник, эдийн засгийн үндэслэлгүй, барилгын ажил эхлэх нөхцөл хангаагүй барилга байгууламжийг төлөвлөгөөнд тусгахгүй байх зарчим баримталж, шаардлага тавьж ажилладаг боловч төсвийн төслийг хэлэлцүүлэх шатанд зураг төсөвгүй барилга байгууламж цөөнгүй тусгагдаж батлагддаг.

Хэдийгээр "Барилгын тухай" хуулийн 15.2-т "Зураг төсөлгүй барилга байгууламжийг улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгахыг хориглоно" гэж заасан байдаг ч энэ нь барилгын ажлыг эхлүүлэх бүх нөхцлийг бүрэн хуульчилж чадаагүй, зохицуулалт нь дутуу хийгдсэн, нөгөөтэйгүүр төсвийн төлөвлөлтийн хуулинд энэ талын зохицуулалт байхгүй байгаа юм.

Зураг төсөв нь бэлэн болсон ч экспертизээр хянагдаж баталгаажсан дүгнэлт, Техник эдийн засгийн үнэлгээ болон үр ашгийн тооцоо, хөрсний инженер-геологийн судалгаа, газрын зөвшөөрөл, мэргэжлийн байгууллагуудаас олгогддог техникийн нөхцлүүд зэрэг нь тухайн барилгын ажлыг эхлүүлэхэд зайлшгүй шаардлагатай зүйл болдог.

Иймд Сангийн яамнаас шинээр боловсруулж Улсын Их Хуралд өргөн барьсан Төсвийн тухай хуулийн төсөлд дээрх бүх шаардлагыг бүрэн хуульчилж тусгасан

болно. Энэхүү зохицуулалтыг хуулийн төслийн 27.1.4; 27.1.7; 27.1.8 дахь заалтуудаар зохицуулахаар тусгаад байна.

Үндэсний аудитын газраас хийсэн судалгаагаар 2010 оны төсвийн тухай хуулинд нийт 223 зураг төсөвгүй барилга байгууламж байна гэж дүгнэсэн бөгөөд эдгээр нь бүгд "Бүс орон нутгийг хөгжлийг дэмжих" хөрөнгө оруулалт нэрээр хуулийн 2 дугаар хавсралтаар батлагдсан юм.

Сангийн яам төсвийн тодотгол хийх үед Үндэсний аудитын газраас зураг төсөвгүй гэж тодорхойлсон тэдгээр төсөл, арга хэмжээ, барилга байгууламжаас нийгэм, эдийн засгийн онцгой ач холбогдолтой гэж үзсэн, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан 7 төсөл, арга хэмжээнээс бусад зураг төсөв нь бэлэн болоогүй, тендер нь зарлагдаагүй төсөл, арга хэмжээг хасч, заримыг нь ТЕЗ-тай тохиролцон зураг төсөвтэй өөр төсөл, арга хэмжээнд шилжүүлэн батлуулах арга хэмжээ авч ажилласан.

Үүний үр дүнд Дэлхийн банкаас Стэндбай хөтөлбөрийн хүрээнд тавьж байсан тусгай шаардлагыг бүрэн хангасан.

3. Тайлангийн дүгнэлтийн 4-д: 2010 онд дэд бүтцийн салбарт төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжээгүй байхад нийгмийн салбарын зарим төсөл, арга хэмжээ төлөвлөснөөс 1.45-1.9 дахин илүү хэрэгжсэн байна гэж үзжээ.

Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлт 2010 онд 89.1 хувьтай гарсан бөгөөд үүнд улсын дунджаас доогуур хувьтай байгаа Ерөнхий сайдын болон Зам, тээвэр, барилга хот байгуулалтын сайдын багцын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлт голлох нөлөөг үзүүлсэн байна.

Монгол Улсын Ерөнхий сайдын багцын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлтийн хувьд Мэдээлэл, харилцаа, холбоо, технологийн газрын захиалгаар БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс хэрэгжүүлэхгүй байхаар шийдвэрлэсэн нь нөлөөлжээ.

Харин Зам, тээвэр, барилга хот байгуулалтын сайдын багцын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлт 81.6 хувьтай гарч, төсөвлөгдсөн хөрөнгөнөөс 35.5 тэрбум төгрөгийг ашиглагдаж чадаагүй нь авто замын салбарт бий болсон үнийн өсөлттэй голчлон холбоотой байсан байна. Сайдын багцын хэмжээнд ашиглагдаагүй хөрөнгийн 75.2 хувь нь авто замын салбарт ногдож байгаа юм.

Төсвийн тухай хуулийн төсөлд үнийн өсөлтөөс шалтгаалсан зохицуулалтыг тодорхой тусгасан бөгөөд Үндэсний статистикийн хорооноос жил бүр үйлдвэрлэлийн индексийг шинэчлэн тогтоож, уг индексийн дагуу барилгын ажлын үнийн өсөлтийг авч үзэж байхаар зохицуулалт хийж байх юм. Одоогоор зөвхөн хэрэглээний үнийн индексийг тооцож байна.

Хуулийн төслийн 27.5-д үйлдвэрлэлийн түүхий эдийн үнийн индекс нь батлагдсан төсөвт тооцсон хэмжээнээс 2 дахин өссөн тохиолдолд барилгын төсөвт өртгийг нэмэгдүүлж байхаар тусгаад байна.

Зарим төсөл, арга хэмжээнд төсөвлөгдсөн хөрөнгө ашиглагдахгүй үлдэж байхад зарим төсөл, арга хэмжээний биелэлт төлөвлөснөөс илүү гарах тохиолдол жил бүр гарч байгаа нь эрхзүйн зохицуулалт байхгүйтэй холбоотой юм.

Иймээс Улсын Их Хурлаас баталсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд зохицуулалт хийж байх талаар шинээр боловсруулсан Төсвийн тухай хуулийн төсөлд тусгаад байна. Хуулийн төслийн 10.1.14-т "тухайн жилийн төсвийн хуулиар батлагдсан хөрөнгө оруулалтын арга хэмжээний жагсаалтад шинэ арга хэмжээ нэмж оруулахгүйгээр, тэдгээрийн гүйцэтгэлийн явц байдалтай уялдуулан, төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын дүнд багтаан хөрөнгийн зохицуулалт хийх" эрхийг Засгийн газрын бүрэн эрхэд оруулсан.

Ингэснээр төсөвлөгдсөн хөрөнгө ашиглагдахгүй үлдэж байгаа болон гүйцэтгэл илүү хийгдэж, хөрөнгө дутагдаж байгаа төслийн хооронд зохицуулалт хийж, төсөвлөгдсөн хөрөнгийг аль болох бүрэн ашиглаж байх боломж эрхзүйн хувьд бүрдэх юм.

4. Тайлангийн дүгнэлтийн 5-д: *Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2010 онд санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээнээс 45.6 тэрбум төгрөгийн 83 ажлын гүйцэтгэл дутуу, хийгдээгүй зөрчил илэрсэн нь нийт хөрөнгө оруулалтын 8.9 хувь нь болж байна гэж дүгнэжээ.*

Өнгөрсөн 2010 онд ашиглагдаагүй хөрөнгийн судалгааг төсөл, арга хэмжээ нэг бүрээр гаргаж үүгээр хүргүүллээ. Авто замын салбарт үнийн өсөлт бий болсон, тендер шалгаруулалт оройтсон, зураг төсөвгүй барилга байгууламж төсөвт тусгагдсанаас шалтгаалан тендер зарлах боломжгүй болсон, төсвийн тодотголыг Улсын Их Хуралд өргөн барьсанаас хойш 2 сар гаруй хугацаа өнгөрч 7 сарын дундуур баталсан, газрын асуудалд маргаан гарсан, зарим гүйцэтгэгч байгууллага гэрээний үүргээ биелүүлээгүй зэрэг олон хүчин зүйл ажлын гүйцэтгэлд сөргөөр нөлөөлсөн байна.

Ашиглалтад орох ёстой нийт 37 барилга ашиглалтад орж чадаагүй бөгөөд тэдгээрт төсөвлөгдсөн 24.1 тэрбум төгрөг 2011 оны төсвийн тодотголд он дамжин тусгагдах шаардлагатай болж байна. Ашиглалтад орж чадаагүй барилга байгууламжийн жагсаалтыг гаргаж тайлбарыг төсөл, арга хэмжээ нэг бүрээр гаргаж үүгээр хүргүүллээ.

Нийт 7 төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээнд 19 төсөл, арга хэмжээ санхүүжилтээ огт аваагүй бөгөөд тэдгээрт төсөвлөгдсөн 14.0 тэрбум төгрөг ашиглагдахгүй үлдсэн байна. Хөрөнгөө огт аваагүй төсөл, арга хэмжээний жагсаалтыг гаргаж, тайлбар, шалтгааныг төсөл, арга хэмжээ нэг бүрээр гарган үүгээр хүргүүллээ.

5. Тайлангийн дүгнэлтийн 6-д: *Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний явцын хяналт хангалтгүй байна гэж дүгнэлт өгчээ.*

Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн явцад хийх захиалагчийн хяналт хангалтгүй байгаатай санал нэг байна.

Үндэсний аудитын газраас өгсөн зөвлөмжийн дагуу Сангийн яам Төсвийн ерөнхийлөн захирагч болон эрх шилжүүлэн авч байгаа аймаг, нийслэлийн засаг дарга нарын хооронд байгуулах жишиг гэрээнд өөрчлөлт оруулж мөрдүүллээ.

Эрх шилжүүлж байгаа болон эрх шилжүүлэн авч байгаа субъектүүдийн хооронд үүрэг хариуцлагыг тодорхой болгох, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих асуудлыг жишиг гэрээнд тусгаж, Үндэсний аудитын газар болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас тус тус санал авч Сангийн сайдын 2010 оны 285 дугаар тушаалаар батлуулсан.

Сангийн яам ТЕЗ-дын багцад хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээ нэг бүрт хяналт тавих боломж хомс байдаг ч 2010 онд Мэргэжлийн хяналтын ерөнхий газартай хамтран баруун аймгуудад баригдаж байгаа авто замын барилга, байгууламжийн ажлын явцад нэгдсэн шалгалт хийж, 2011 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд шалгалтын дүнг танилцуулах арга хэмжээ авлаа.

Барилгын ажлын чанарт сөргөөр нөлөөлж байгаа нэг хүчин зүйл бол зураг төсөв зохиох ажил бөгөөд Мэргэжлийн хяналтын ерөнхий газартай хамтран Монгол Улсын хэмжээнд үйл ажиллагаагаа явуулж байгаа авто зам, барилга, эрчим хүчний салбарын зураг төсөв зохиодог байгууллагуудад нэгдсэн шалгалтыг энэ оны 5 сард хийхээр төлөвлөж, удирдамжаа батлуулаад байна.

Энэхүү шалгалтыг Үндэсний аудитын газартай хамтран хийхээр төлөвлөж албан тоот хүргүүлсэн боловч шалгалтыг түүгээрээ зохион байгуулах чиглэл өгсөн билээ.

Хөрөнгө оруулалтын үр дүнг дээшлүүлэх, хяналтыг сайжруулах чиглэлээр Сангийн дэд сайдаар ахлуулсан ажлын хэсгийг Сангийн сайдын 2011 оны 79 тоот тушаалаар байгуулан ажиллуулж байгаа бөгөөд саналаа 5 дугаар сард багтаан Засгийн газарт танилцуулахаар ажиллаж байна. Уг ажлын хэсэгт Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын дарга, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, яам, агентлаг, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Монголбанк, Үндэсний статистикийн хороо, зарим их дээд сургууль, хувийн хэвшлийн төлөөлөл орсон юм.

Түүнчлэн, төсвийн хөрөнгө оруулалтын үр дүнг дээшлүүлэх, илэрч буй зөрчлийг арилгах, хяналтын механизмыг боловсронгуй болгох, зарим тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зорилгоор Сангийн яамнаас "Хөрөнгө оруулалтын үр дүнг дээшлүүлэх нь" сэдэв онол, практикийн бага хурлыг энэ 5 дугаар сарын 27-нд зохион байгуулахаар төлөвлөж байна.

Энэхүү хурал, хэлэлцүүлэгт бүх яам, аймаг, нийслэлийн хяналт шалгалтын байгууллагууд, Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо, гишүүд, эрдэм шинжилгээний байгууллагууд, их дээд сургууль, зарим төрийн бус байгууллагыг оролцуулахаар урьсан бөгөөд хурлаас зөвлөмж гарган Засгийн газарт хүргүүлж, холбогдох шийдвэрийг гаргуулахаар ажиллаж байна.

6. Тайлангийн дүгнэлтийн 7-д: Гэрээний нөхцлөө биелүүлээгүй гүйцэтгэгч байгууллагатай хариуцлага тооцох арга хэмжээ сул байна гэж дүгнэжээ.

Сангийн яам гэрээ байгуулахад оролцдоггүй бөгөөд гэрээний үүргээ зөрчсөн гүйцэтгэгч нартай зөвхөн захиалагч байгууллага хариуцлага тооцох хэлбэрээр ажиллаж байна.

Сангийн яам шинээр боловсруулан Улсын Их Хуралд өргөн барьсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай

хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд гэрээний үүргээ ноцтой зөрчсөн гүйцэтгэгч нарыг хар жагсаалтад оруулах, тэдгээрийг дахин тендер шалгаруулалтад оролцуулахгүй байх зохицуулалтыг хуульчилж өгөхөөр ажиллаж байна.


7. Тайлангийн “Зөвлөмж” хэсэгт Сангийн сайдад “Өмнөх онуудын хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд тус газраас хийсэн аудитаар өгөгдсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх”-ийг зөвлөмж болгосон байна.

Аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр тус яамнаас анхаарч ажиллан 2009 оны хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд хийсэн аудитын тайлангийн зөвлөмжийн хүрээнд хууль, эрх зүйг боловсронгуй болгох, хөрөнгө оруулалтын хэрэгжилтийн хяналтыг сайжруулах чиглэлээр холбогдох арга хэмжээнүүдийг авч, зөвлөмжийн хэрэгжилтийг Үндэсний аудитын газарт хүргүүлж ажиллав. Дээрх зөвлөмжийг ерөнхий байдлаар бус, илүү тодорхой болгох нь зүйтэй байна.

Аудитын тайлангийн төсөлд өгч буй тайлбар, саналыг анхаарна уу.

Хавсралт: 29 хуудас.

Хүндэтгэсэн,

САЙД  С.БАЯРЦОГТ



Тайлбар:

Тайлбар 1

Ирүүлсэн саналыг хүлээн авлаа.Тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Нэг.Монгол Улсын Сангийн сайд С.Баярцогтод:

1. Өмнөх онуудын хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд Үндэсний аудитын газраас хийсэн аудитаар өгөгдсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх арга хэмжээ авах;

Хоёр. Зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулгад:

1. Хөрөнгө оруулалтын хэрэгжээгүй төсөл, арга хэмжээний шалтгааныг судалж, холбогдох арга хэмжээ авах;
2. Гүйцэтгэгч байгууллагуудтай авлага, өглөгийн тооцоо нийлж, баталгаажуулан төсвийн хөрөнгөөр хийгдсэн зураг төсвийн үнийг бүртгэлд тусгаж байх.

Гурав. Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригтод:

1. Ашиглалтад орсон объектуудыг Сангийн сайдын 135 дугаар тушаалаар батлагдсан журмын 3.23 дугаар заалтын дагуу бүртгэлд тусгах.

Дөрөв.Төсвийн ерөнхийлөн захирагч нарт:

1. Худалдан авах ажиллагааг ТБОНӨХБАҮХАТХ болон журмын дагуу зохион байгуулаагүй холбогдох ажилтнуудад хариуцлага тооцох;
2. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн үе шатны хяналтыг салбарын онцлогийг харгалзан оновчтой зохион байгуулж, орон нутагт эрх шилжсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний хяналтыг сайжруулах, гэрээний үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгчтэй хариуцлага тооцож байх.

(Хавсралт № 1)

**УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ 2010 ОНЫ
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНД ОРУУЛСАН ӨӨРЧЛӨЛТ**

(сая төгрөгөөр)

Төсвийн ерөнхийлөн захирагч	2010 оны төлөвлөгөө	Өөрчлөлт		2010 оны тодотгосон төлөвлөгөө
		Нэмэгдсэн	Хасагдсан	
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТГ-ЫН ДАРГА	189.2	89.2	89.2	189.2
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА	1,840.0	65.0	1,065.0	840.0
МОНГОЛ УЛСЫН ҮАБЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА	105.3	-	-	105.3
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР	200.0	-	-	200.0
ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДАРГА	45.7	117.8	-	163.5
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА	91.4	-	-	91.4
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД	11,194.8	3,554.8	-	14,749.6
МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР САЙД	5,346.3	6,347.0	140.0	11,553.3
МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД	8,198.1	1,941.8	2,060.0	8,079.9
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА	6,015.3	1,093.0	955.8	6,152.5
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД	4,071.4	-	-	4,071.4
САНГИЙН САЙД	17,634.9	5,076.0	1,800.0	20,910.9
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД	15,259.2	1,128.0	20.0	16,367.2
ЭРДЭС БАЯЛАГ, ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД	42,435.9	17,420.7	7,638.5	52,218.1
ЗАМ, ТЭЭВЭР, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД	144,553.5	63,610.6	15,132.6	193,031.5
НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙД	14,188.4	24,108.6	-	38,297.0
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД	34,763.9	8,808.5	225.5	43,346.9
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД	66,674.1	9,981.4	1,177.3	75,478.2
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД	3,283.8	-	-	3,283.8
ХХАА, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД	34,493.7	2,967.3	1,405.3	36,085.7
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД	2,210.0	1,175.9	-	3,385.9
ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА	1,342.9	-	-	1,342.9
УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ШҮҮГЧ	118.8	-	-	118.8
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГА	91.4	-	-	91.4
УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР	306.5	-	-	306.5
МҮОНРТ	500.0	-	-	500.0
ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ УЛСЫН ТӨСВӨӨС ШИЛЖҮҮЛСЭН ХӨРӨНГӨ	32,604.0		(32,604.0)	-
ДҮН	447,758.5	147,485.6	31,709.2	530,960.9

10	Жижиг Дунд үйлдвэрлэлийг дэмжих /Өвөрхангай/	2010	1 280,0	1 280,0	1 280,0	1 280,0	128,0	1	1	1	90	-	1 280,0	1 280,0	1 280,0	1 280,0	1 280,0	1 280,0	1 280,0	128,0	1	1	1	Батлагдсан хөрөнгийн зориулалтыг өөрчилж, 303,9 сая төгрөгөөр техник хэрэгслийг шууд гэрээгээр худалдан авсан, үлдэгдэл 446,0 сая төгрөгийг улсын төсөвт төвлүүлээгүй, ТЭДС-нд үлдэгдэлтэй байгаа бөгөөд нэмж техник хэрэгсэл худалдан авахаар төндөр шалгаруулсан байна.
11	Ахуйн үйлчилгээний сэлбэр, фермерийн аж ахуй, жижиг, дунд үйлдвэрлэл хөгжүүлэх төсөл /Сүхбаатар, 13 сум/	2010	235,0	235,0	235,0	235,0	22,6	1	1	1	89,3	-	235,0	235,0	235,0	235,0	235,0	235,0	235,0	22,6	1	1	1	Зарим олгосон зээлийг зориулалтын дагуу ашиглаж байгаа эсэх болон эргэн төлөгдөх эсэх нь тодорхой бус байна. Зарцуулагдаагүй үлдэгдлээс 2,5 сая төгрөгийг Хилийн цэргийн ангийн халуун усны засварын ажилд олгож, бусад 22,5 сая төгрөгийг сум жижиг дунд байршуулан үлдээснийг Сүхбаатар аймгийн аудитын газар төсөвт төвлөрүүлэхээр акт бичсэн.
12	Жижиг, дунд бизнесийг дэмжих /Хэнтий/	2010	600,0	600,0	600,0	600,0	529,8	1	1	1	11,7	-	600,0	600,0	600,0	600,0	600,0	600,0	600,0	529,8	1	1	1	Хэнтийн аймгийн сумдад 530,0 сая төгрөгийг банкаар дамжуулалгүй, хүүгүйгээр зээл хэлбэрээр олгосон, үлдсэн 70,0 сая төгрөгийг ХХАХУСалбарын багцад хамааралгүй арга хэмжээнд зарцуулжээ (авагзам, байрны засвар, Ахмадын хороонд микрорайгобус авсан)
13	Малын чанар, үүлдэр угсааг сайжруулах хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлж эхлэх /Өмнөговь/	Цөм сургийн үржлийн төв 2010	30,0	30,0	30,0	30,0	30,0	1	1	1	0	-	30,0	30,0	30,0	30,0	30,0	30,0	30,0	30,0	1	1	1	Гүйцэтгэхээр шалгарсан төв нь "үржлийн мал бойжуулж борлуулах" тусгай зөвшөөрөлгүй байсан тул санхүүжилт хийгдээгүй, одоо мал хамгаалах санд байршиж байна.
VII Сангийн яам /ГЕГ/																								
14	Гаалийн нэг цэгийн үйлчилгээний төвийн барилга /Увс/	2008-2010	3 580,0	1 180,0	1 180,0	1 180,0	59,0	1	1	1	95	-	1 180,0	1 180,0	1 180,0	1 180,0	1 180,0	1 180,0	1 180,0	59,0	1	1	1	Гүйцэтгэхээс үл шалтгаалсан, зураг, төсөв өөрчлөгдсөөс нэмэлт ажил гарсан
15	Чингэлзэг шалгах рентген төхөөрөмжийн гадна авто зам, талбай, инженерийн шугам сулжээ, хашаа гэрээтүүлэг, үзэлийн тавцан /Замын-Үүд/	2009-2010	1 000,0	1 000,0	1 000,0	1 000,0	90	1	1	1	20,5	20,5	979,5	979,5	1 000,0	1 000,0	1 000,0	1 000,0	1 000,0	100,0	1	1	1	Гүйцэтгэхээс үл шалтгаалсан, шилэн кабелийн шугам шилжүүлэх нэмэлт ажил гарснаас хугацааг сунгасан
VIII БСШУЯ																								
16	Монгөн сургуулийн өргөтгөл, спорт заалны барилга	2008-2010	629,0	335,0	319,7	319,7	15,3	56	1	1	147,4	15,3	319,7	335,0	629,0	629,0	629,0	629,0	629,0	147,4	1	1	1	Өмнө нь шалгарсан МБУ ХХК ажлаа 30 хувийн гүйцэтгэлтэйгээр дуу хийж орхиноос БСШУЯ гэрээг гүйцэтгэх шинээр Зострейд ХХК-ыг шалгаруулсан.
17	Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын 320 хүүхдийн сургууль, спорт заалны барилга	2006-2010	860,0	139,0	139,0	139,0	45	1	1	1	76,5	-	139,0	139,0	860,0	860,0	860,0	860,0	860,0	76,5	1	1	1	Өмнөх гүйцэтгэгч спорт заалны БУА-ыг гүйцэтгэх боломжгүй мэдэгдэж, гэрээт ажлыг дуу гүйцэтгэсэн. 721 сая төгрөгийг Дэлгэринтөрийн ХХК Шинээр "Суварга эв" ХХК-тай гэрээ байгуулаж 139 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэн, заалын барилгын суурь зассан, заалны төмөр карказ зангидаж эхлэж байна, материал татан авалт хийгдсэн.
18	Уламжлалт аягадах ухааны корпорацийн уламжлалт эмийн үйлдвэр	2008-2010	1 164,0	664,0	649,1	649,1	98,4	14,9	98,4	1	10,6	14,9	649,1	664,0	1 164,0	1 164,0	1 164,0	1 164,0	1 164,0	10,6	1	1	1	Цахилгаан, бохир усны техникийн нөхцөл өөрчлөлт орсноос гэрээт хугацаанд ашиглалтад ороогүй.
19	Нийслэлийн БГД-ийн 1-4 хорооны 640 хүүхдийн сургууль	2008-2011	1 900,0	800,0	800,0	800,0	50	1	1	1	400,0	-	800,0	800,0	1 900,0	1 900,0	1 900,0	1 900,0	1 900,0	400,0	1	1	1	920 хүүхдийн суудалтай төлөвлөгдсөн боловч олгогдсон газрын багтаамжаас шалтгаалж суудлын тоог 640 болгож зурга төсөвт өөрчлөлт орсон, 1,849,9 сая төгрөгөөр гэрээ байгуулсан
20	СХД-ийн 38-р цэцэрлэгийн барилга	2007-2010	224,8	10,0	10,0	10,0	98,4	-	98,4	1	0,2	-	10,0	10,0	224,8	224,8	224,8	224,8	224,8	0,2	1	1	1	Гадна цахилгааны эх үүсвэр шийдвэргүйгээс ашиглалтад ороогүй
21	Ховд аймгийн Жаргалант сумын 320 хүүхдийн сургуулийн барилга	2008-2010	1 200,0	640,0	500,8	500,8	139,2	74,4	1	1	163,8	139,2	500,8	640,0	1 200,0	1 200,0	1 200,0	1 200,0	1 200,0	163,8	1	1	1	Газрын байршил өөрчлөгдсөөс цэвэр бохир усны сүлжээ, дэд өргөөний байршил өөрчлөгдсөн, ажил гүйцэтгэх явцад спорт заал нэмж барихаар болсон.
22	СБД-ийн 16-р хорооны цэцэрлэгийн барилга	2008-2010	505,0	410,2	410,2	410,2	75	-	75	1	102,6	-	410,2	410,2	505,0	505,0	505,0	505,0	505,0	102,6	1	1	1	Газрын захирал өндөр хүчдэлийн шугамын дор гарснаас цахилгааны техникийн нөхцөл өгөөгүй, Дахин газрын захирал гарч 2010-9 сард барилга угсралтын ажил эхэлсэн одоо техникийн комисс ажиллахаад бэлэн болж байна.

38	ХБНГУ-ын Сэргээн босголтын банкны зээлийн хөрөнгөөр хэрэгжж буй Дарханы дулааны цахилгаан станцын турбины шинэчлэлт	2009-2012	"Мон Угсралт" ХХК	3 000.0	900.0	900.0	0	900.0	1	2010 оны 2 сард тендерийн үнэлгээний хороо байгуулагдсан боловч 2010.07 сард тендерийн урилгыг нийтлэж хугацаа алдсан, тендерийн үнэлгээний маргаанаас шалтгаалж гүйцэтгэчийг сонгон шалгаруулаагүй.
39	Зуунмод хотын 4-р дунд сургууль, Халдвартын эмнэлгийн өргөтгөл, "Ирээдүй" цэцэрлэгийг газрын гүний дулааны нөөцийг ашиглан дулааны эрчим хүчээр хангах	2010	"Мон Угсралт" ХХК	1 360.0	1 358.6	1 354.5	4.1	135.9	1	Зураг экспөртээр баталгаажуулах байснаас ажил эхлэх хугацаа хохиолсон, хүлгийн улиралд хийх боломжгүйгээс хугацаандаа хэрэгжээгүй
40	УБ хотын Умард дэд станцын трансформатор, хаалттай хуваарилах байгууламжийн өргөтгөл, шинэчлэлт хийх	2009-2010	"Илч хангай" ХХК	2 750.2	10.6	10.0	0.6	95	1	Төлөвлөсөн ажлыг хугацаанд нь бүрэн гүйцэтгээгүй
41	УБ хотын төвд 35/06 кВ-ын дэд станц, газар доогуурх кабель,	2007-2009	"Хасуу эрчим" ХХК	1 586.5	34.4	20.9	13.5	98	1	Зураг экспөртээр баталгаажуулах, гүйцэтгэгч агаарын орууллын зураг, төслийн дагуу хийгээгүй, дэд өргөөний барилгыг сөндөрчөн хавтангаар гүйцэтгэсэн нь галын шаардлага хангаагүй.
42	"Хайлааст" дэд станцаас Яргайт дэд станц хүртэл 35кВ-ын 2 хэлхээт 9 км цахилгаан дамжуулах шугам/УБ/	2009-2010	"Тэнгэр уул" ХХК	897.6	18.4	18.4	98	0.4	1	ЭХ-ний шугам сулжээг хамгаалах дүрмийн 2.3.1а-д, "35 кВ хүргэлт цахилгаан дамжуулах шугам хүн оршин суудаг газраар өнгөрөх нөхцөлд шугамын захын утаснаас 2 тийш 4 метрээр зай хэмжээг тогтооно гэсэн заалтыг зөрчсөн, зураг төсөлд тусгагдаагүй нэмэлт ажил гарсан.
43	Ховд аймгийн Дуг-Баян-Өлгий аймгийн Булган сумын 15кВ-ын 109 км ЦДАШ, 0.4/15 кВ-ын 1х0.25 мВА, 15/0.4 кВ-ын 2х0.16 мВА-ын дэд станц, Баян-Өлгий/	2008-2009	"СММС" ХХК	1 300.0	20.0	20.0	-	75	1	Зураггүй ажлаа гүйцэтгэж эхэлсэн, трассын дагуу хад асга илгэй, цас их ордогос хүнд даацын машинаар ачаа тээвэрлэх боломжгүй зэргээс шалтгаалж нэмэлт тээврийн зардал гарсан.
44	500 кВ- чадал бүхий дизель станц худалдан авч суурилуулах /Завхан/	2010	"Бодь электроникс" ХХК	550.0	550.0	530.0	20.0	78	1	Тонго төхөөрөмжийг дугуу суурилуулсан
45	Эмээлтэд 2х1.6 мВА чадалтай 35/10 кВ-ын дэдстанц, 4км цахилгаан дамжуулах шугам, 10/0.4 кВ-ын шугам, АТП/УБ/	2009-2010	"Илч хангай" ХХК	2 549.6	10.0	10.0	-	98	1	Зарим шкаф солигдоогүй, Техникийн комиссоос өгсөн зарим үүрэг биелэгдээгүй.
46	Хайлааст гэр хорооллын дэд станц 110/35/10 кВ, 2х16.0 мВА, /УБ/	2007-2009	"Автоматика" ХХК	2 524.4	23.6	23.6	23.6	98	1	Хөрсний суулт өгдгөөс улсын комисс хүлээн авах боломжгүй.
47	Аймгийн 0.4 кВ-ын эрчим хүчний СИП шугам тавих /Архангай, Эрдэнэбулган, Их тамир, Эрдэнэмандал, Батцэнгэл, Булган, Чулуут, Төвшүүлэх сумд/ Балц-1, Архангай аймгийн Эрдэнэбулган сум	2010	"Альяс тех" ХХК	650.0	650.0	650.0	-	90	1	УИХ-н гишүүн Н.Батбаярын саналаар Эрдэнэбулган сумын шугамын зураг төсөвт өөрчлөлт оруулснаар тендер шалгаруулалтын хугацаа оройтсон, Г-рээнд ажил эхлэх, дуусах хугацаа бичигдээгүй.
48	Улаанбаатар хотын 6-10 кВ-ын кабель шугамын шинэчлэл, /УБ/	2010	"УБЦТС" ТӨХК	1 300.0	1 300.0	1 290.0	10.0	90	1	Гэрээний хугацааг 2 удаа сунгасан боловч техникийн нөхцдөөс шалтгаалж ажил бүрэн хийгдээгүй
XI	ЗТБХБ-ын сайд									
49	АХБ-ны зээлээр хэрэгжүүлэх "Бус нутгийн авто зам хөгжүүлэх төсөл"-ийн Сайншанд-Замын-Үүд чиглэлийн 131.2 км хатуу хучилттай зам /Дорноговь/	2006-2010	Чайна Жео Инженеринг ХХК	3 609.0	1 666.7	141.8	1 524.9	4	1 600.0	Гадаадаас ажиллах хүч авах зөвшөөрөл оройдогоос ажил оролтож эхэлдэг, хугацаа сунгаснаас төсөвт өртөгөө багтахгүй нэмэлт хөрөнгө шаардлагатай болсон
50	АХБ-ны зээлээр хэрэгжүүлэх "Бус нутгийн авто зам хөгжүүлэх төсөл"-ийн Сайншанд-Замын-Үүд чиглэлийн 62 км хатуу хучилттай зам /Дорноговь/	2007-2010	Шинли инженеринг ХХК	1 638.1	912.5	413.9	486.6	25	684.4	Гадаадаас ажиллах хүч авах зөвшөөрөл удааширч ажил оролтож, хугацаа сунгаснаас нэмэлт хөрөнгө шаардлагатай болсон

51	АХБ-ны эзэлээр хэрэгжүүлэх "Бүс нутгийн авто зам хөгжүүлэх төсөл"-ийн Сайшианд-Замын-Үүд чиглэлийн хатуу хучилттай замаас Өргөн сум хүртэлх 18.25 км хатуу хучилттай зам /Дорноговь/	Шинли инженеринг ХХК	2007-2010	630.1	515.1	39.8	475.3	6	484.2	1	1	Гадаадаас ажиллах хүч авах зөвшөөрөл оройдгоос ажил оройгож эхэлдэг, хугацаа сунгаснаас төсөвт өртөгтөө багтахгүй нэмэлт хөрөнгө шаардлагагүй болсон
52	Ховдын Булган-Үенч-Ховд чиглэлийн 40 км хатуу хучилттай авто зам	Чигтай ХХК	2007-2010	6 800.0	2 350.2	449.6	1 900.6	70	705.1	1	1	Гадаадаас ажиллах хүч авах зөвшөөрөл оройдгоос хугацаа алдсан, материалын үнийн өсөлтөөс барилгын ажил төсөвтөө багтахгүй болсон, гүйцэтгэгч компанийн ажлын зохион байгуулалт хангалтгүй
53	Ховдын Булган-Үенч-Ховд чиглэлийн 20 км хатуу хучилттай авто зам	Чигтай ХХК	2008-2010	3 849.0	2 672.5	611.4	2 061.1	30	1870.8	1	1	Гадаадаас ажиллах хүч авах зөвшөөрөл оройдгоос хугацаа алдсан, материалын үнийн өсөлтөөс барилгын ажил төсөвтөө багтахгүй болсон, гүйцэтгэгч компанийн ажлын зохион байгуулалт муу
54	Дашинчилэн-Орхоны гүүр чиглэлийн 30 км хатуу хучилттай авто зам	ЗМЗ ХХК	2007-2010	5 350.4	1 516.9		1 516.9	60.0	1516.9	1	1	"ЗМЗ" компани нь гэрээт хугацаандаа ажлыг гүйцэтгээгүй тул гэрээг цуцалсан
55	Халзанбүргэдэй /Гариаг/- Соловгийн даваа чиглэлийн 100 км хатуу хучилттай авто зам /Архангай/	ӨМӨЗО-рны 2 дугаар барилга ХХК	2008-2011	20 000.0	9 170.4	5 076.4	4 094.0	35	5 960.8	1	1	Гэрээ байгуулсан эхний 2 жилд төсөвт өртгийн 18 хувийг төлөвлөсөн, материалын үнийн өсөлтөөс ажил төсөвт өртөгтөө багтахгүй болсон, ажиллах хүчний зөвшөөрөл оройгож гарсан, гүйцэтгэгч компанийн ажлын зохион байгуулалт хангалтгүй.
56	Баянхонгор-Арвайхээрийн 27 км хатуу хучилттай авто зам /Баянхонгор/	Улаанбаатар АЗЗА ХК	2008-2010	5 500.0	2 871.9	1 440.2	1 431.7	70	861.6	1	1	Гэрээ байгуулсан эхний 2 жилд төсөвт өртгийн бага хувийг олгохоор төлөвлөснөөс материалын үнийн зөрүү гарч, төсөвт өртөгтөө багтахгүй болсон. Түншлэгч "Ялгуусан" ХХК УБ хотод өндөр өртөгтэй ажлууд хийснээс машин механизм хүн хүч хүрэхгүй болсон
57	Баянхонгор-Нерийтгэлийн 50 км хатуу хучилттай авто зам /Баянхонгор/	Төв АЗЗА ХК	2008-2010	9 516.5	6 066.5	2 957.9	3 108.6	55	1331.1	1	1	Гэрээ байгуулсан эхний 2 жилд төсөвт өртгийн 30 хувийг олгохоор төлөвлөснөөс материалын үнийн зөрүү гарч, төсөвт өртөгтөө багтахгүй болсон, ажлын зохион байгуулалт муу. Түншлэгч "Цайлан" ХХК машин механизмын хүчин чадал муу, ажлын харилцлага сул
58	Өндөрхаан-Чойбалсангийн чиглэлийн 50 км хатуу хучилттай зам /Хэнтий/	Насны зам ХХК	2008-2011	10 000.0	7 000.0	5 224.2	1 775.8	55	2 350.9	1	1	Гэрээ байгуулсан эхний 2 жилд төсөвт өртгийн 20 хувийг олгохоор төлөвлөснөөс материалын үнийн зөрүү гарч, төсөвт өртөгтөө багтахгүй болсон, гүйцэтгэгч олон ажлыг /Булган-Увс чиглэлийн 60 км зам, Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн 143 км зам, Тавантолгой Гашуунсухайн чиглэлийн зам/ зэрэг хийх болсноос машин механизм, хүн хүч дутагдсан
59	Мөрөн-Хатгалын 50.0 км хатуу хучилттай зам /Хөвсгөл/	Аржипитгал ХХК	2008-2011	9 613.2	3 500.0	3 326.9	173.1	40	2 100.0	1	1	Гэрээ байгуулсан эхний 2 жилд төсөвт өртгийн 7.8 хувийг олгохоор төлөвлөснөөс материалын үнийн зөрүү гарч, төсөвт өртөгтөө багтахгүй болсон, гүйцэтгэгч компани төлөвлөсөн хөрөнгийг бүрэн ашигласан.
60	Мөрөн-Хатгалын 48.8 км хатуу хучилттай зам /Хөвсгөл/	Ялгуусан ХХК	2008-2011	9 757.8	3 405.4	1 209.7	2 195.7	15	2 894.6	1	1	Гэрээ байгуулсан эхний 2 жилд төсөвт өртгийн 7.8 хувийг олгохоор төлөвлөснөөс материалын үнийн зөрүү гарч, төсөвт өртөгтөө багтахгүй болсон. Гүйцэтгэгч "Ялгуусан" компани УБ хотод өндөр өртөгтэй ажлууд хийснээс гадна Арвайхээр-Баянхонгор чиглэлийн 27 км замд түншлэгчээр, Талсагбулагийн газрын тосны хайргам замд гүйцэтгэгчээр ажиллаж машин механизм хүн хүч хүрэхгүй болсноос ажлыг дуутуу гүйцэтгэсэн.
61	Хэнтий голын төмөр бетон гүүр-Халсан бүргэдэй чиглэлийн 59.8 км хатуу хучилттай зам /Кагарын буцалтгүй тусламж	Монроуд ХХК	2008-2011	10 883.2	3 755.1	2 667.2	1 087.9	85	563.3	1	1	7.8 дугаар сард бороо их орсноос асфальт бетонон ажил саатсан, гүйцэтгэгч өөр ажилд тоног төхөөрөмж, ажиллах хүчээ татан ажиллуулсан, материалын үнийн өсөлтөөс төсөвт өртөгтөө багтахгүй болсон

62	Цэцэрлэг-Их тамир-Тосонцэнгэл чиглэлийн 53 км хайрган замыг хатуу хучилттай болгох	Хурды зам ХХК	2007-2010	8 296.0	1 874.4	1 187.2	687.2	80	374.9	1	1	1	374.9	7.8 дугаар сард бороо их оросноос асфальтбетоны ажил саатсан, гүйцэтгэгч өөр ажилд тоног төхөөрөмж, ажиллах хүчээ татан ажиллуулсан, материалын үнийн өсөлтөөс төсөвт өртөгтөө багтахгүй болсон, зураг төсвийн алдаанаас төлөвлөгдөөгүй ажил нэмэгдсэн
63	Хөвсгөл Мөрөн хотын тавийн 1.1 км хатуу хучилттай авто зам	Композит-Асмо ХХК	2009-2010	239.9	73.5		73.5	30	73.5	1			73.5	Гэрээг цуцалсан
64	Баруун 4 зам 10-р хорооллын уулаарын авто замын өргөтгөл шинэчлэл, 1.6 км /УБ/	Хотын зам ХХК	2009-2010	2 465.1	1 015.6	699.7	315.9	70	304.7	1	1		304.7	Нийслэлд эрх шилжсэн. Он дамжин хийгдэх ажил тул 2011 онд хийгдэх ажлын хөрөнгө Нийслэлийн төрийн санд үлдсэн.
65	Тээлийн голын 75 у/м төмөр бетон гүүр /УБ/	Мөнхжим ХХК	2005-2010	488.8	292.6		292.6	40	292.6	1			292.6	Гэрээ цуцалсан
66	Туул голын Горхийн 211 у/м төмөр бетон гүүр /УБ/	Гангүүр ХХК	2007-2010	2 422.5	588.8	403.8	185.0	90	56.9	1	1		56.9	Материалын үнийн өсөлтөөс шалтгаалан үнийн зөрүү гарч, төсөвт өртөгтөө багтахгүй болсноос ажил зогссон.
67	Идэрийн голын 169.08 у/м төмөр бетон гүүр /Завхан, Их Уул/	Завхан АЗЗА ХК	2008-2010	1 593.4	918.9		918.9	40.0	918.9	1	1		918.9	Гэрээ цуцалсан
68	"Зорчигч үйлчилгээний төв" авто воззалын барилга /Дархан, 3-р хороолол/	Эм Би Си Си ХХК	2008-2010	1 414.1	1 213.4	1 191.2	22.2	95	60.7	1	1		60.7	Барилгын гадна тохижилтын ажил хийгдээгүй
69	Нисэх буудлын онгоц хөөрч, буух хатуу хучилттай зурвас, үерийн далан /Завхан/	Хурды зам ХХК	2008-2010	8 651.5	3 151.5	155.1	2 996.4	60	1260.6	1	1		1260.6	Аэропромын барилга угсралтын ажлын гүйцэтгэлийн явцад зураг төсөвт өөрчлөлт хийх шаардлага гарсанаас .
70	АХБ-ны зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй "Хот байгуулалтын салбар" төслийн дотоод эх үүсвэр	Төслийн нэгж	2008-2012	2 970.2	500.0	349.4	150.6	70	150.0	1	1		150.0	Эрдэнэт хотын гэр хорооллын усан хангамж, ариутгах татуураг, цэвэрлэх байгууламжийг сайжруулах барилгын ажлын зургаг, төсөл оройтож гарсан, тендер хугацаа алдсанаас ажил хийгдээгүй
71	АХБ-ны буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй "Эр хорооллыг олон нийтийн орлоцтой хөгжүүлэх" төслийн дотоод эх үүсвэр	Төслийн нэгж	2007-2011	195.0	33.0	8.9	24.1	4.5	31.5	1	1		31.5	Төлөвлөсөн ажил хийгдээгүй
72	АХБ-ны зээлээр хэрэгжүүлэх "Бүс нутгийн авто зам хөгжүүлэх төсөл"-н Сайншанд-Замын Үүд чиглэлийн хатуу хучилттай замаас Эрдэнэ сум хүртэлх 15.5 км хатуу хучилттай авто зам /Дорноговь/	Чайна Жео Инженеринг ХХК	2010-2011	735.8	500.0	97.9	402.1	13	435.0	1			435.0	Гадаадаас ажиллах хүч авах зөвшөөрөл оройтогдоос ажил оройтож эхэлсэн.
73	Германы сэргээн босголт банкны зээлээр хэрэгжүүлэх "Нийслэл хотын хүнсний найдвартай байдлыг хангах орон нутгийн тээврийн дэд бүтцийг хөгжүүлэх төсөл"-н 78.6 км хатуу хучилттай авто зам /Төв-Борнуур, Жаргалант/	Төслийн нэгж	2010-2012	2 504.3	360.0	18.9	341.1	5.3	340.9	1	1		340.9	2010 оны 12 дугаар сард зээлийн гэрээ УИХ-аар соёрхон батлагдсан
74	Кувейтийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх Унйт-Тариалан чиглэлийн хатуу хучилттай зам /Булган/	Төслийн нэгж	2010-2012	6 050.0	605.0	40.8	564.2	7	562.7	1			562.7	Зээлийн гэрээ 2010 оны 7-р сард батлагдсан. Гүйцэтгэгчиг шалгаруулах тендер зарласан ч Кувейт-Монголын хамтарсан компани оролцохоор зээлийн гэрээнд заасан, 1 км замыг барих өртөг бага байгаа зэрэг шалтгаанаас ажил нь эхлээгүй, урсгал зардалд хөрөнгө зарцуулсан
75	УБ-Мандагловь чиглэлийн хатуу хучилттай авто зам	Энч Кэй Би Интернэшл холдинг ХХК	2010	4 500.0	4 500.0	4 302.4	197.6	96	180.0	1			180.0	Барилгын ажлыг дуусгах комисст хүлээлгэн өгсөн, батлагтаг засварын хугацаанд хийгдэх нэмэлт ажлын санхүүжилтийг авч үлдсэн
76	Төмөр зам дээгүүр тавигдсан явган хүний гарцын шинэчлэл /Дархан-Уул/		2010	35.0	35.0		35.0	0	35.0	1			35.0	Орон нутагт эрх шилжсэн, хийгдээгүй ажил

77	Онгоц хөөрч Буух хатуу хучилттай зурвасын шинэчлэлт /Хөвсгөл, Мөрөн/	КТК ХХК	2010-2011	4 000,0	890,0	267,0	623,0	65	311,5	1	1								Урьдчилгаа авсан, гүйцэтгэлийг гаргаж өгөөгүй.
78	ХУД-ийн 1 дүгээр хороо 36 айлын орон сууцны гадна инженерийн шугам сүлжээ	Альянс тех ХХК	2010	152,7	152,7	134,9	17,8	88	18,3	1	1								Төлөвлөсөн ажлыг бүрэн хийгээгүй тул дугуу санхүүжүүлсэн
79	Инженерийн шугам сүлжээ, төвлөрсөн ус, хангамжийн систем, цэвэрлэх байгууламжийн өргөтгөл, шинэчлэлт /Өвөрхангай, Хархорин/	Эс энд Эй трейд ХХК	2010-2012	3 300,0	1 000,0	567,1	432,9	20	800,0	1									ХАА-ны маргаанаас шүүхийн шийдвэрээр ажлыг зогсоосон
80	Гэр хорооллын усан хангамжийг сайжруулах /Хөвсгөл, Мөрөн/	Боорчи ХХК	2010	300,0	300,0	272,3	27,7	90	30,0	1	1								Төлөвлөсөн ажлыг бүрэн хийгээгүй тул дугуу санхүүжүүлсэн
81	Дулааны шугам сүлжээний өргөтгөл /Увс, Улаангом/		2010	750,0	750,0		750,0	90	750,0	1		1							Орон нутагт эрх шилжсэн, хийгээгүй. Зураг төсөв хийгээгүй тул 2010 онд ажил хийгээгүй.
82	1-11-р хороонд байрлах орон сууцны хороололд 300-ийн цэвэр усны шугам тавих /УБ, ХУД/		2010	200,0	200,0		200,0	0	200,0	1		1							Зураг төсөвгүй, УСУГ-аас техникийн нөхцөл олгоогүй, ажлын зориулалтыг өөрчлөх санал шийдвэрлэгдээгүй
83	Тоног төхөөрөмж 11 тоног төхөөрөмж		2010	3 632,5	3 632,5	2 603,2	1 029,3	70	781,0	1									Төндөр оролтож зарлагдсан, ажлын гүйцэтгэл оройтсоноос 11 тоног төхөөрөмж нийлүүлэгдээгүй
НИЙТ ДҮН						53 159,6	44 017,6		45 682,3	21 62	14	25	16	19	8	1			



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ**

2011 оны 5 сарын 26 өдөр

Дугаар 51

Улаанбаатар хот

┌ Аудитын тайланг баталгаажуулах тухай ┐

Төрийн аудитын тухай хуулийн 13.4.5, “Гүйцэтгэлийн шалгалтын журам”-ын 23 дугаар зүйлийн 2, “Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам”-ын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ нь:


Нэг. “Улсын төсвийн хөрөнгөөр 2010 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.

Хоёр. Гүйцэтгэлийн аудитаар илэрсэн төлбөр, зөрчлийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

Гурав. Аудитын тайланг Сангийн сайд С.Баярцогт холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт хүргүүлсүгэй.

Дөрөв. Аудитын тайланд дурьдагдсан зөрчлүүдийг арилган, өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, түүний үр дүнг 2011 оны 11 дүгээр сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт танилцуулахыг Сангийн сайд С.Баярцогт, төсвийн ерөнхийлөн захирагч нарт зөвлөсүгэй.

Тав. Аудитын тайланд тусгагдсан зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг энэ онд багтаан Удирдлагын зөвлөлд танилцуулахыг Гүйцэтгэлийн аудитын газрын захирал Д.Ганбилэгт даалгасугай.



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

Ч.РАДНАА

Төсөл I

070140